

БӨХӨНГИЙН МЭДЭЭ

Бөхөнгийн хамгаалал, экологийн талаар мэдээлэл солилцох зургаан хэл дээр гарч буй хэвлэл



Зургийг: Н.Синех.

Яншулийн үржүүлгийн газарт буй бөхөнгийн ооно. ОХУ.

Биологич-агнуур зүйчдийн олон улсын холбооны XXIX чуулганаар бөхөнгийн асуудлыг хэлэлцэв

Бөхөн (*Saiga tatarica*) хамгаалах олон улсын хамтын ажиллагаа нь биологич-агнуур зүйчдийн олон улсын холбооны (ОУБАЗХ) XXIX –р чуулганы хэлэлцээрийн тусгай сэдэв боллоо. (Москва хот, 2009 оны 8-р сар).

ОХУ-ын хөдөө аж ахуйн яам, Зэрлэг амьтан хамгаалах, ашиглах олон улсын зөвлөлийн (ЗАХАОУЗ) дэмжлэгтэйгээр чуулганд бөхөн тархсан орнуудын ихэнх шинжээч төлөөлөгчид оролцсон нь чуулганы хөтөлбөрт бөхөнгийн хамгааллын сэдэв чухал байр суурь эзлэхэд түлхэц болов.

Өргөн хуралдаан дээр «Хүн ба шим мандал» Юнескогийн хөтөлбөрийн Оросын хорооны орлогч дарга, ОУБАЗХ шинжлэх ухааны хорооны гишүүн, бөхөн хамгаалахын төлөө олон жил цуцалтгүй ажиллаж буй доктор Валерий Михайлович Неронов илтгэл тавилаа. Илтгэлд сүүлийн жилүүдэд бөхөн хамгаалах үйл хэрэгт орон нутгийн болон олон улсын байгаль хамгаалах холбоод, улс орны засгийн газрууд ихээхэн үр дүнд хүрч буйг тэмдэглэхийн зэрэгцээ

үргэлжлэл 2-р нүүрт

Доорх байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэгддэг

Төгсгөл (эхлэл 1-р хуудасанд.)

бөхөнгийн асуудал урьдын адил хүндрэлтэй бөгөөд үүнийг шийдэхэд илүү тогтвортой санхүүгийн болон байгууллагуудын оролцоо дэмжлэг ялангуяа ОХУ-д шаардлагатай буйг тэмдэглэсэн.

Бөхөн хамгаалах олон чиглэлийн асуудалд чиглэсэн салбар хуралдаан чуулганы дөрөв дэх өдөр боллоо. Өглөөний хуралдаанд 90 орчим хүн оролцож, 8 илтгэл, 7 ханын илтгэлийг Украйнаас («Аскания-Нова» шим мандлын дархан газарт олон жил болж буй бөхөнгийн үржүүлгийн популяцийн динамикийн тухай сонирхолтой илтгэлийг В.С.Гавриленко тавьсан.) ОХУ, Казахстан, Узбекистан, Монгол (Б.Чимэддорж монгол бөхөнгийн мониторинг явуулахад болон нутгийн иргэдийн оролцоотой бөхөн хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд авч байгаа гол арга хэмжээнүүдийн талаар илтгэсэн) хүртлэх бөхөн тархсан орнуудын төлөөлөгчид хэлэлцүүлсэн. Түүнчлэн Монголын төлөөлөгчийн илтгэлд эхэндээ маш олон янзын үзэл бодол, хандлагатай байсан нь орон нутгийн болон байгаль хамгаалах чиглэлийн олон улсын мэргэжилтнүүд хамгааллын асуудлыг амжилттай шийдэхийн тулд үндсэн асуудлууд, арга замдаа харилцан зөвшилцөн шийдэж хамтдаа үр дүнд хүрч буйг сайтар харуулсан байна.

Алматад бөхөн хамгаалах харилцан ойлголцлын тунхаглалд нэгдсэн орнуудын зөвлөлдөх явцад 2006 онд бөхөн тархсан орнуудын зөвшөөрсөн дунд хугацааны ажлын хөтөлбөрийн (ДХАХ) биелэлтийн үр дүнгүүдийг илтгэгчид тавьсан. Хөтөлбөрт бөхөн хамгаалахад шаардлагатай үйл ажиллагааг дурьдаж, зүйлийн төлөв байдалд нөлөөлөх чухал бөгөөд хойшлуулашгүй нэн тэргүүний гэж ангилсан. Илтгэлүүдийг сонссоны дараа хуралдаанд оролцогчид тодорхой амжилтанд хүрсэн ДХАХ-ийн чиглэлүүдийг онцгой ялган, түүнчлэн одоохондоо биелэгдээгүй чиглэлүүдийг гаргасан тогтоолыг гаргалаа. Ялангуяа олон улсын худалдааны чиглэлээр амжилт гарахгүй байгаа нь бас чухал орхигдсон ажил юм. ДХАХ-ийг 5 жилээр (2011 он хүртэл) тооцсон бөгөөд бөхөн хамгаалахад олон улсын хүчин чармайлтыг нягтруулах, мониторингийн хэрэгсэл болгох нь чухал болно. Тогтоолыг бөхөн хамгаалах холбооны интернет хуудас болон *Stepной бюллетень* сэтгүүлд (№29, 2009) хэвлүүлсэн. Орой нь бөхөн хамгаалах холбооны (БХХ) жил болгоны уулзалт болсон.

БХХ бол бөхөн хамгаалах чиглэлээр ажиллаж буй мэргэжилтэнүүдийн олон улсын сүлжээ бөгөөд түүний гишүүн байгууллагуудын нэг нь ЗАХАОУЗ юм.

Мэдээ

Халимагт 2010 оныг бөхөнгийн жил болгон зарлалаа

Халимагийн Бүгд Найрамдах Улсын тэргүүн Кирсан Илюмжинов Халимагт 2010 оныг бөхөнгийн жил болгон зарласан тухай №422 дугаартай тогтоолд гарын үсэг зурлаа. Халимагийн бүгд найрамдах улсын нутаг дэвсгэрт европийн бөхөнгийн популяцийг хамгаалахын тулд хууль сахиу байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, түүнчлэн бөхөн хамгаалалын үр дүнг сайжруулах комплекс арга хэмжээг боловсруулахын тулд үүнийг хийсэн. Бөхөнгийн жилийг явуулах, бэлтгэхэд зохион байгуулах хороог Бүгд найрамдах



Бөхөнгийн тусгай хуралдааны оролцогчид-2009.

Бөхөн хамгаалах холбооноос (БХХ) жижиг төслийн сонгон шалгаруулалтын дүнг танилцуулсан нь уулзалтын гол үйл явдал байв. Уралдааны зорилго бол томоохон санхүүжилт авах боломжгүй, бөхөн тархсан орнуудад жижиг төслүүдийг дэмжих замаар орон нутгийн түвшинд бөхөн хамгаалах боломжийг бүрдүүлэхэд оршино. Ийм төслүүд ДХАХ-ийг биелүүлэхэд дэмжлэг болдог. Энэ жил, өмнөх жилүүдийн адилаар жижиг төслийн хөтөлбөрүүдийг байгаль хамгаалах олон улсын сүлжээ (БХОУС) болон анх удаагаа зэрлэг амьтан хамгаалах, ашиглах олон улсын зөвлөлөөс (ЗАХАОУЗ) санхүүжүүлж дэмжив. БХХ-ны гүйцэтгэх зөвлөл Бөхөн хамгаалах холбооны үйл ажиллагааны хүрээ болон янз бүрийн орнуудыг хамарсан 4 төслийг дэмжсэн (*цааш хараарай*).

Холбооны удирдлагын бүтэц, шинэ дүрмийг баталсанаар түүнийг Их Британид сайн дурын байгууллага болгон бүртгүүлэх боломжтой болж байгаа юм.

Түүнээс гадна, бөхөн хамгаалах холбооны үйл ажиллагааны бусад чиглэлийн амжилтууд, Бөхөнгийн мэдээний албан сэтгүүлийг гаргах тухай ч хэлэлцсэн. Бөхөнтэй холбоотой бас нэгэн сонирхолтой үйл явдал чуулганы хамгийн сүүлчийн өдөр болов. Холбооны гишүүн, Халимагийн бөхөнгийн экологи судлаач Надежда Арыловад Биологич-агнуур зүйчдийн олон улсын холбооноос залуу эрдэмтдийн дунд хамгийн сайн илтгэл шалгаруулах уралдааны гурав дахь шагналыг гардуулсан. Ингэж үнэлсэн нь Халимагийн бөхөнгийн ирээдүй найдвартай гарт гэж итгэх итгэл байна.

Профессор Э.Дж. Милнер-Гулланд

Лондонгийн эзэн хааны коллеж, БХХ-ийн дарга

e.j.milner-gulland@imperial.ac.uk

Халимагийн засгийн газар 1-р сарын 14-нд бөхөнгийн жилийг явуулах арга хэмжээний төлөвлөгөөг баталлаа. Зохих баримтанд Бүгд найрамдах улсын засгийн газрын тэргүүн Владимир Сенглеев гарын үсэг зурлаа. Батлагдсан төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээнүүдийг явуулахаар болов:

1. Бөхөн хамгаалах тусгайлсан отрядыг байгуулж, үйл ажиллагааг зохион байгуулах
2. Республикийн Дотоод хэргийн яам, «Черные земли» Шим мандлын дархан газрын оролцоотойгоор бөхөн хамгаалах хамтын гэнэтийн шалгалтуудыг явуулах
3. Онгоц болон дулаан мэдрэмжтэй зургийн хэрэгсэл ашиглан бөхөнгийн тооллого, мониторингийг зохион байгуулж явуулах
4. Үржүүлгийн газарт өсгөсөн бөхөнгүүдийг байгальд нь тавих туршилтыг орчин цагийн радио дохиолол, мониторингийн арга хэрэглэн турших
5. Бөхөнгийн шаргачинг зохиомолоор хээлтүүлэх туршилтыг явуулах
6. Бөхөнгийн популяцийг хамгаалах, сэргээх чиглэлээр оросын болон гадаадын эрдэмтэдтэй хамтын ажиллагааг идэвхжүүлэх ажлуудыг явуулах
7. Бөхөнгийн популяцийг хамгаалах, сэргээх чиглэлээр олон улсын эрдэм шинжилгээ-практикийн хурлыг зохион байгуулж явуулах
8. Бөхөнгийн эврээс гаргаж авдаг бодисуудыг зохиомолоор нийлэгжүүлэх судалгааны санаачилгат ажлыг явуулах



Зургийг Р.Рыбачка

Бөхөнгийн шинэ төрсөн янзага

Түүнээс гадна арга хэмжээний төлөвлөгөөнд бөхөнгийн сэдэвт баримтат кино, үзэсгэлэн зэрэг залуучуудын дунд янз бүрийн уралдааныг явуулахаар болсон байна. Дэлгэрэнгүйг:

<http://www.elista.org/elista/pravitelstvom-rk-utverzhdjen-plan-meropriyatiy-po-provedeniyu-goda-sa.html>
<http://www.elista.org/elista/izvestiya-kalmykii-13.01.10-2.html>

Хээрийн туруутаны амьдрах орчноор аялах анхны олон улсын экоаялал Бөхөнгийн жилтэй давхацав

Английн Eastern Approaches компани, Ростовын компани «Сайга тур» болон Бөхөн хамгаалах холбоо хамтран ОХУ-ын өмнөд нутагт бөхөнгийн амьдрах орчноор экологи, соёлын аялал жуулчлалыг 2010 оны 8-р сард хийхээр төлөвлөж байна. Аялалаар бөхөн хамгаалах холбооны гол төслүүд хэрэгжиж буй нутгууд болон «Яшкульский» бөхөн үржүүлгийн төв, «Степной» байгалийн нөөц газруудыг үзэж сонирхох болно.

Бөхөнтэй холбоотой анхны экологийн аялал жуулчлалыг нь олон чиглэлээр сонирхсон хүмүүст зориулагдсан, үнийн чөлөөт сонголтыг санал болгосон байх болно гэж бид үзэж байгаа. Бөхөнгийн жилд эхэлж байгаагаараа энэ санаачлага цагаа олсон юм. *Нэмэлт мэдээлэл болон бүртгүүлэх хуудсыг интернет хуудаснуудаас авч болно:* www.easternapproaches.co.uk

Казахстаны үндэсний ололт бөхөнгийн хамгаалал

Ой, агнуурын аж ахуйн орлогч дарга Игорь Коваль өөрийн илтгэлдээ бөхөнгийн хамгааллын асуудлыг хөндлөө. Түүний илтгэлд бөхөнгийн хамгаалал, тусгай хамгаалалттай газруудыг байгуулахад улсаас гаргаж буй хөрөнгийн хүчээр энэхүү үнэ цэнэтэй агнуурын амьтны тоог нэмэгдүүлж чадсан гэж өгүүлсэн.

Тэрээр бөхөнгийн өнөөгийн тоо толгойг 80 мянга гэж үнэлж, цаашдаа ч тоо толгой хурдан өсөх боломжтой хэмээн таамаглал дэвшүүлжээ.

Дэлгэрэнгүйг: <http://sim.kz/?p=3114>

Узбекистаны хүчний байгуулагууд бөхөнгийн хамгаалалд нэгдэхэд бэлэн байна.

Узбекистанд 2009 оны 10-12-р саруудад бөхөнгийн жишээн дээр ховор амьтныг хамгаалах асуудлаар бүгд найрамдах улсын хүчний байгууллагуудын мэдээллийг нэмэгдүүлэх талаар хэд хэдэн семинарыг зохион байгууллаа. Семинарыг Ташкент, Нукус болон Устюртийн тэгш өндөрлөгийн хоёр сууринд хийсэн. Узбекистаны амьтан судлалын хүрээлэн, бөхөн хамгаалах эвсэл, Узбекистаны байгаль орчны улсын хороо,

Каракалпакстаны бүгд найрамдах улсын байгаль орчны улсын хороо FFI –ийн дэмжлэг, Disney Worldwide Conservation Fund сангийн санхүүжилтээр семинаруудыг зохион байгуулсан.

Семинарын үйл ажиллагаанд байгаль хамгаалах ашиглах байгууллагуудын ажилчидын хамт Улсын гаалийн хороо, Узбекистан, Каракалпакстаны Дотоод хэргийн яам,

Узбекистаны улсын хил хамгаалах хороо, Аралын байгаль хамгаалах прокурор болон бусад сонирхсон байгууллагуудын төлөөлөгчид оролцлоо. Байгаль орчны олон улсын болон үндэсний хууль тогтоомжтой нийцсэн, зэрлэг амьтны зүйлүүдийг оруулж, гаргах гаалийн хууль дүрэмтэй зохицсон байгаль орчны салбарт байгууллага хоорондын харилцааг сайжруулах боломжит арга замуудыг хэлэлцсэн. Семинарын оролцогчид байгаль хамгаалах хууль тогтоомжын биелүүлэх арга туршлагаасаа хуваалцсан. Хулгайн анчдын ашигладаг тээврийн хэрэгсэл, буу зэвсэг ихэнхдээ бүртгэлгүй байдаг учраас бөхөн болон бусад ховор зүйлүүдийг хамгаалах бодит ажил хэрэгт бүгд найрамдах улсын байгаль хамгаалах болон хүчний байгууллагуудын хүчийг нэгтгэх шаардлагатай.

Семинарын дүнд бөхөн болон түүнээс гаралтай эд зүйлийг бүгд найрамдах улсын нутаг дэвсгэрээс хууль бусаар гаргах болон оруулж ирсэн тохиолдлуудын талаар байгууллага хоорондын мэдээллийн солилцоог сайжруулах тухай шийдвэр гарсан.



Семинарын үеэр Нукуст



Ташкент- семинарын оролцогчид .

Зургийг А.Есипова

Каракалпакстаны байгаль орчны улсын хорооны суурь дээр мэдээллийн төвийг зохион байгуулах санал гарсан. Үүнд Каракалпакстанд Амударийн сав газарт тугайн ойг хамгаалах ГЭФ/ПРООН төслөөр байгаль орчны улсын хороонд үлдээсэн техник хэрэгсэл, байр сав бэлэн бий. Түүнээс гадна, семинарт оролцогчид эхний ээлжинд бөхөн тархах нутгуудад нүүдлийн болон үржлийн үед байгаль орчны байцаагчид, Дотоод хэргийн яамны ажилчдын хамтын гэнэтийн шалгалт явуулах тухай шийдвэр гаргасан. Семинарын оролцогчид байгаль хамгаалал болон хууль тогтоомжын талаар төрийн байгууллагын ажилтнуудыг сургах, нэмэлт мэдээлэл бүхий материалуудыг гаргах шаардлагатай хүлээн зөвшөөрөв.

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Елена Быкова, esipov@xnet.uz болон Мариу Карлстеттер, Maria.Karlstetter@fauna-flora.org, нарт хандана уу

Хятадын уламжлалт анагаах ухаан бөхөнг хамгаалах гол түлхүүрийг барьж байна

Хятадын уламжлалт анагаах ухаанд зориулсан олон улсын хурал, үзэсгэлэн 2009 оны 11-р сарын 9-нээс 11-ны хооронд Хятадын Гуанжоу мужийн Баюнь олон улсын ордонд болж өнгөрлөө. Хурлыг Хятадын шинжлэх ухаан техникийн яамнаас 14 зохих байгууллагуудын дэмжлэгтэйгээр зохион байгуулав. Хуралд 18 мужаас хувиараа бизнес эрхлэгч, төрийн байгууллагуудын ажилчид, эрдэмтэд зэрэг 2800 гаруй хүмүүс оролцсон. Түүнчлэн 340 гаруй эрүүл мэндийн компаниуд өөрсдийн бүтээгдэхүүнүүдээ дэлгэн оролцлоо. Хуралдаан 9 академик салбар хурал, 8 зэрэгцээ явагдсан арга хэмжээнээс бүрдсэн. Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн (ЗАХН) Хятадын хөтөлбөрийн захирал доктор Си Янь болон ЗАХН-ийн жижиг төслүүдийн хөтөлбөрийн баг хуралд оролцож бөхөнгийн талаар мэдээллийн хуудсуудыг тараасан. Доктор Си Янь бөхөн хамгаалахад Хятадын уламжлалт анагаахын түлхүүр үүргийн тухай илтгэл хийлээ. Бөхөнгийн хамгаалал, болон өнөөгийн нөхцөл байдал, ялангуяа бөхөнгийн эврийн хэрэгцээ их байгаа нь энэ зүйлийн байгаль дээрх хорогдол хууль бус агнуурын шалтгаан болж буй тухай өгүүлсэн. Төгсгөлд нь хятадын уламжлалт эмчилгээний чиглэлээр ажилдаг мэргэжилтнүүд, эрдэмтэд, бусад оролцогчдыг бөхөн болон уламжлалт анагаах ухаанд ашигладаг



Доктор Си Янь, ЗАХН-ийн хятадын хөтөлбөрийн захирал хурал дээр илтгэж байна.

Зургийг Гуйхон Цзяну

бусад ховор зүйлүүдийг хамгаалахад оролцохыг уриалав . Доктор Си Янь бүх оролцогчдод байгаль хамгаалах санааг дэлгэрүүлэх, өөр орлуулах эх үүсвэр олох судалгаа явуулахыг уриалав

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Гуйхон Цзяну, gzhangwcs@gmail.com, хандана уу.

Сан-Францискод болсон байгаль хамгаалах үзэсгэлэн

Дженни Леон

Папуа Шинэ Гвинейн эртний имжээс эхлээд Африкийн заан хүртлэх олон зүйл амьтдын хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллагууд оролцсон Байгаль хамгаалах олон улсын сүлжээний (БХОУС) 8-дахь үзэсгэлэн 2009 оны 10-р сарын эхний долоо хоногт боллоо. Бөхөнгийн талаарх мэдээллийг түгээх, цаашдын хамгаалалд зориулагдах санхүүгийн дэмжлэг олох зорилготойгоор бөхөн хамгаалах холбоог (БХХ) төлөөлөн Елена Быкова бид оролцлоо. Долоо хоногийн эхнээс л байгаль хамгааллын салбарын мэргэжилтнүүдэд зориулсан семинаруудаар үргэлжилж маркетингийн (Бөхөнгийн мэдээ сэтгүүлийг хэвлэлтийг сайжруулах тусгай зөвлөмжүүд) үнэ цэнэтэй зөвлөгөөг сонсож, Google Earth программын сүүлийн үеийн верси болон хандивлагчидтай уулзах үеэр санхүүгийн дэмжлэг олох хамгийн сайн арга замуудын тухай мэдэж авлаа.



Зургийг Мартина Варона

Сан-Францискод болсон хурлын төвд БХХ-ны ширээ.



Зургийг Мартина Варона

БХОУС экспо үзэсгэлэнгийн тусгай зочны сонирхолтой илтгэл – д-р Дж. Гудалл.

Хандивлагчидтай уулзах эхний уулзалтаас эхлэн оройн коктейлийн үеэр бид шинэ мэдлэгээ ашигласан. Энэ хүлээн авалтан дээр ойролцоогоор 150 хандивлагч оролцсон бөгөөд байгаль хамгаалах салбарт хамгийн нэр хүндтэй, доктор Дж.Гудалл голлон оролцлоо. Дараагийн өдөр өглөө эрт бид Сан-Франциско руу олон нийтэд нээгдсэн үзэсгэлэн рүү явлаа. Бөхөн хамгаалах холбооны ширээ заалын төв хэсэгт байршиж байв. Энэ нь БХОУС-ний гишүүд, байгаль хамгааллын мэргэжилтнүүд амьтад, тэдгээрийн хамгааллын үйл ажиллагааны талаар 30 минутын үзүүлэн хийсэн хурлын зал руу орж байгаа болон гарч байгаа бүх хүмүүсийн анхаарлыг татахад сайн байв. Бөхөнтэй хамааралтай БХХ-ноос хамгааллын чиглэлийн олон арга хэмжээ, тархсан улс орнуудын олон мэдээлэл, баримт агуулсан фото зургууд бүхий илтгэл тавьсан Еленад маш олон хүмүүс баяр хүргэж байсан.

Оклендийн амьтны хүрээлэнгийн хүүхдүүд болох эртний танилуудтайгаа бид илүү ойр танилцсан бөгөөд тэд ч биднийг хармагцаа манай ширээ рүү гүйж ирсэн. Эдгээр хүүхэд залуус ямар их сонирхож байгааг харахад сайхан байсан бөгөөд цаашид амьтны хүрээлэнгүүдтэй илүү нягт харилцааг бий болговол үнэхээр гайхалтай. Хүүхдүүд бөхөнгийн тухай анх удаагаа тухай хоёр жилийн өмнө сонссож тэр үеэс л бөхөн сонирхож эхэлснийг илүү дэлгэрэнгүй ойлгоход иймэрхүү төрлийн арга хэмжээнүүд үр дүнтэй болохыг харуулж байна. Хандивлагчидтай уулзах төгсгөлийн уулзалтыг БХОУС-г үндэслэгч Чарли Нолесийн гэрт Лос-Альтост бүтэн сайн өдөр боллоо. Энэ үдэшлэг шинэ танилтай болох, БХХ-ны хандивлагчидтай уулзаж тав дахь өдөр эхэлсэн яриагаа үргэлжлүүлэх боломжыг бидэнд олгосон юм. Байгаль хамгаалах чиглэлийн мэргэжилтнүүдэд өөрийнхөө байгууллага, хамгаалж буй зүйлүүд, өөрсдийгөө танилцуулах боломжтой байв. Тэдний хооронд амьтдынхаа «хамгийн сонирхолтой» онцлогоор уралдаан ч болов; жишээлэхэд цагаан толгойт тамариныг «хамгийн аятайхан сармагчин», харин бөхөнг «хамгийн ер бусын хамар» цолоор өргөмжлөв. Үдэшлэг дээр хоёр гайхалтай хөгжмийн хамтлагууд тоглож, БХОУС-ний сайн дурынхан амттай хоолоор дайлж, харин «Леопард ба бусад» байгууллага олон нийтэд зэрлэг муурнууд үзүүлэв.

Ерөнхийдөө аялал амжилттай, үр дүнтэй болсон. Бөхөн хамгаалах үйл ажиллагаанд хэд хэдэн хувь хандивлагчдыг татаж чадсан гэж бид итгэж байна. Түүнээс гадна, бөхөнгийн амьдрах орчноор хандивлагчдыг аялуулах экоаялалыг хөгжүүлэх, гар урлалын бүтээгдэхүүнүүдийг борлуулах арга хэлбэрийн тухай олон шинэ санаа, зөвлөгөө өгсөн олон мэргэжилтэнгүүдтэй бид уулзалдсан. Эдгээр санаануудыг БХХ-г ивээгчдийн зөвлөлийн хуралдаан дээр хэлэлцэх болно. Бидэнд ийм боломж олгосон БХОУС-ний төв болон тэдний сайн дурынханы багт талархал илэрхийлэхийг хүсэж байна.

Нэмэлт мэдээл авахыг хүсвэл Елена Быковад esipov@xnet.uz болон Дженни Леон, jenny.leon08@imperial.ac.uk нарт хандана уу

Амьтныг хамгаалах долоо хоног!



Жил бүр дэлхий даяар амьтны эрхийг хамгаалах олон улсын сангаас (АЭХОУС) амьтныг хамгаалах долоо хоногийг зохион байгуулдаг. Ийм долоо хоногийг 2009 оны 9-р сарын 21-нээс 10-р сарын 2-ны хооронд Халимагийн бүгд найрамдах улсын А.В.Очировагийн нэрэмжит Гашунскийн ерөнхий боловсролын дунд сургууль дээр Халимагийн зэрлэг амьтны төвийн мэргэжилтэнгүүдийн

Орос Хятадын хилийн бүс дэхь хууль бус барааны худалдаа эргэлт буурахгүй байна.

Жил бүр Оросын ДБХС, Алс Дорнод дахь TRAFFIC хөтөлбөр, Оросын гаалийн академийн Владивостокийн салбарын байгаль хамгаалахад гаалийн оролцоо сургалт аргагүйн төвийн ажилчид Приморск, Хабаровскийн хязгаарын хилийн хотуудын дэлгүүр захуудаар, түүнчлэн ховор амьтан ургамлын болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүнүүдийн худалдааг хянах зорилготойгоор Хэйлуунцзян мужид (Хятад) мониторинг хяналтыг хийв. Энэхүү ажлыг ид худалдааны үе : 4-ээс 9-р саруудад хийлээ.



Зурвалж: USFWS

удирдлага дор өнгөрүүлэв. Энэхүү арга хэмжээнүүдэд бөхөн онцгой байр суурь эзлэж байсан ба түүнийг хамгаалах төслүүдийг олон жилийн турш АЭХОУС – гаас дэмжиж байгаа. Шилдэг экологийн зураг, үзүүлэн, шилдэг шүлэг, өгүүлэг зэргээр сурагчдын дунд явуулсан уралдаанаас харахад бидний жижигхэн «ах дүүс» амьтдын ертөнц өсөж буй залуу үеийнхэнд огт хамаагүй зүйл биш юм байна.

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Т.К.Босхондэжиева болон Ю.Н.Арылову, kalmsaiga@mail.ru нарт хандана уу

ОХУ-ын нутаг дэвсгэр дээр энэ жил хөдөөгийн суурин газруудад 10 байнгын болон 13 түр зуурын захуудыг хянаж шалгасан. Зэрлэг ургаж буй ургамал, мөөг, амьтдыг хууль бусаар бэлтгэж агнах нь ихээхэн түгээмэл үзэгдэл болох нь судалгаагаар харагдсан. Олонх худалдагчид бэлтгэх, нийлүүлэх, хуулийн хориглосон тогтоол журмыг мэдэх боловч нэмэлт орлого олох хүсэл нь хүмүүсийг ийм хууль бус зүйл хийхэд хүргэж байна. Мониторингийг мөн хилийн гадна талд ч явуулав. Хятадад ч мөн амьтны болон далайн гаралтай бүтээгдэхүүнээр худалдаа хийдэг захууд, уламжлалт эмчилгээнд хэрэгтэй бараа түүхий эдийн худалдааны бөөний захууд, улсын болон хувийн 10 аптекуудад судалгаа хийв. Худалдаанд буга, бор гөрөөс, бөхөн, трепанг, хүдэр, сивуч, зэрлэг ургадаг хүн орхоодой зэрэг амьтан ургамлаас гаралтай бүтээгдэхүүнүүд, янз бүрийн зүйлийн мэлхийнүүд байв. Барааны тодорхой хэсгийг Оросоос оруулж ирсэн гэдгээ ч худалдаачид өөрсдөө нуугаагүй, тэдний ихэнх нь амьтан ургамлын эд эрхтний хэсгүүдийг хууль бусаар оруулж ирсэн байсан ч хамгаагүй авах сонирхолтой байгаагаа нуухгүй байв. Биологийн нөөцийн хууль бус худалдааны томоохон хэмжээний эргэлт чухам орос-хятадын хил дээр болж буй нь эндээс харагдаж байна.

Дэлгэрэнгүйг http://www.uralpolit.ru/federal/polit/e_s_r/id_156245.html

Бөхөнгийн тооллогыг Монголд хийв.

MAVA-ийн төслийн хүрээнд 2009 оны 10- сарын 11-12-нд монголд бөхөнгийг тооллогыг байгаль хамгаалагчдын оролцоотойгоор хийлээ. Байгаль хамгаалагчид GPS ашиглан нэгэн зэрэг цэгэн тооллогыг явуулав. Бүх байгаль хамгаалагчид дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулах талаар зааварчилгаа авсан байсан. Бөхөн байршсан мэдээллээс гадна, цаг хугацаа, өдөр, ажиглагчийн нэр, цаг агаарын байдал, сүргийн бүтэц, хэмжээ, бөхөнгийн зан төрх, амьдрах орчны мэдээллийг бүртгэсэн. Бөхөнгийн мэдэгдэж буй тархацын 70% хувьд судалгаа хийж 380 сүргийн 4022 бодгаль тэмдэглэсэн. Сүргийн дундаж хэмжээ 10,5 (1-73) бодгаль байв. Шарга болон Хүйсийн говиудын дэд популяциудын хоорондох нүүдлийн шилжилтийг холбодог коридори нутгуудад нийтдээ 85 сүргийн 942 бодгаль (23,4%) бөхөн бүртгэсэн.



Зурвалж: MAVA

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Б. Чимэддорж руу хандана уу, chimeddorj@wwf.mn

Бөхөнгийн тоо 2009 онд нэмэгдлээ.

«Өнгөрсөн жил бөхөнгийн тоо 32,7 %-иар өсч 81 мянган толгой хүрсэн нь байгалийн жамаараа нөхөн үржихэд таатай боломж бүрдлээ» - Казахстаны бүгд найрамдах улсын хөдөө аж ахуйн сайд Ахылбек Куришбаев захиргааны коллегийн 1-р сарын 18-ны

өргөтгөсөн хурал дээр зарлалаа. Түүний үгээр бол ховор болон устах аюулд ойрхон зэрлэг амьтдын хамгааллын ажлууд хяналт шалгалтын албаныханы үйл ажиллагаа идэвхжсэнээр эрс сайжирсан байна. Дэлгэрэнгүйг <http://inform.kz/rus/article/2228351>.

«Степной» нөөц газарт хулгайн анчин баригдав

«Степной» байгалийн нөөц газрын нутаг дэвсгэр дээр Лиманский районд 2009 оны 9-р сарын 1-нд бөхөн хууль бус агнасан үйлдлийг илрүүллээ. Мотоцикл ашиглан бөхөнг хөдөлж чадахгүй болтол нь элдэж хөөгөөд модоор цохиж алсан байв. Нөөц газрын болон Астраханск мужийн улсын хяналт шалгалтын

албаныхантай холбоотой ажилласаны дүнд хулгайн анчинг саатуулсан. Тэрээр Халимагийн Бүгд найрамдах улсын Яшкуль суурингийн оршин суугч байв. ОХУ-ын УК-ийн 258-р зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. Шалгалт явагдаж байгаа.

Дэлгэрэнгүйг <http://www.astrakhan.net/?ai=21863>.

Казахстанд хулгайн анчдыг илрүүлсэн тохиолдлууд

Казахстанд хулгайн анчдыг саатуулсан саяхны тохиолдлууд олон бий.

Бетнакдалинскийн популяцид:

«Охотзоопром» -ийн РГКП байцаагчид 2009 оны 9-р сарын 21-нд ИЖ мотоциклээр бөхөн хууль бус агнасан Жайрем суурингийн оршин суугч 36 настай иргэнийг саатуулсан байна. Саатуулагдсан этгээдийг нэгжих үед бөхөнгийн 2 ооно, буу, дуран, сумны хуй илрүүлж хураасан. Түүнээс гадна, саатуулсан газрын ойролцоо 3 ширхэг бөхөнтэй нуувчыг илрүүлсэн. Хэргийн баримт, нотолгоонуудыг 2009 оны 9-р сарын 22-нд Карангандинск мужийн Нуринскийн Дотоод хэргийн газарт шилжүүлсэн.

“Казахстаны өнөөдөр” сонин мэдээлсэнээр 2010 оны 1-р сарын 4-нд Иргизскийн дотоод хэргийн газрын ажилчид "Иргиз-Торгай" нөөц газрын нутаг дэвсгэр дээр "ИЖ-Планета" улсын дугааргүй мотоцикл унасан Казахстаны Кызылординск мужийн Аральск районы Акеспе суурингийн 33 настай иргэнийг саатуулсан байна. Үзлэгийн явцад эврийг нь хөрөөдөж авсан 5 бөхөн, хоёр амтай 16-ийн калибр ангийн буу, 50 ширхэг сум илэрчээ. Одоогоор энэ хэрэгт Казахстаны УК-ийн 288 зүйлээр эрүүгийн хэрэг үүсгэх тухай асуудал шийдэгдэж байгаа (хууль бус ан). Дэлгэрэнгүйг <http://kt.kz/index.php?lang=rus&uin=1133168020&chapter=1153497956>; <http://kt.kz/index.php?lang=rus&uin=1133168020&chapter=1153506653>.

Устюртскийн популяцид:

Дагалдах ямар ч бичиг баримтгүйгээр хоёр бөхөн агнаж машиндаа хийсэн байсан хоёр хулгайн анчинг Жулдуз сууринд саатуулсан. Устюртийн тэгш өндөрлөгт Актюбинск мужид 10-р сарын 13-нд Актаугийн иргэн 16 бөхөн агнажээ. Хулгайн анчинг «Охотзоопром» байцаагчид саатуулан барьжээ. Ангийн байцаагчид 10-р сарын 25-нд жип машиныг шалгахаар зогсоох гэсэн байна. Зогсохын оронд зугтсан учир байцаагчид араас нь хөөжээ. Мөрдөх явцад тэд машинаас давхих явцдаа 3 бөхөн, буугаа гаргаж шидэхийг харсан байна. Гурван хүнийг саатуулж, эрүүгийн хэрэг үүсгэсэн.

Дэлгэрэнгүйг

<http://kt.kz/index.php?lang=rus&uin=1133168098&chapter=1153500005>; <http://diapazon.tv/2009/10/28/sajjgu-bjut-no-ona-ne-vymiraet.html>.

Уралийн популяцид:

2009 оны 10-р сарын 20-нд Сайхан суурингаас гарах үед нь байцаагчид цаасан хайрцаганд бөхөнгийн 88 эвэр боож хийсэн «ГАЗель» машиныг саатуулсан байна. Саатуулсаны дараа эрэгтэй хүн өөрөө агнаагүй, харин ширхэгийг нь 300-аас 1000 хүртлэх тенгегээр нутгийн иргэдээс худалдаж авсан гэж мэдүүлсэн. Тэрээр тэдгээрийг Алмата руу гаргаж худалдах санаатай байсан байна. 44 бөхөн агнаж ой ангийн санд учруулсан хохирол 11 сая 404 мянган тенгегээр үнэлэгдсэн. Дэлгэрэнгүйг <http://diapazon.tv/2009/10/28/sajjgu-bjut-no-ona-ne-vymiraet.html>.

Казахстанд авлигатай тэмцэл хийж байна

Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэсээс Актюбинск мужийн орон нутгийн ой, ангийн аж ахуйн даргын орлогч Гусевт бөхөн агнах зөвшөөрлийг хууль бусаар олгосон хэмээн хатуу шийтгэл оноожээ.

Дэлгэрэнгүйг

<http://diapazon.tv/kazakhstan/20245-44-gossluzhashhikh-uvoleny-v-jetom-godu-po.html>.

Хятадын шоронд Кыргызстаны 9 иргэн шийтгүүлээд байна

Хүн амины хэрэг, хар тамхи хууль бус давуулж наймаалсан, бөхөнгийн эвэр хууль бус наймаалсан Кыргызстаны иргэдийг шийтгэсэн. Нэгэнд нь цаазлах ял оноосон боловч сүүлдээ 19 жил хорих ял болгож өөрчилсөн. Хоёр иргэнийг бүх насаар нь хорих ял шийтгэсэн.

Өөр дөрвөн иргэнд шийтгэлийг урт хугацаа болгож өөрчилсөн. Одоогоор Кыргызстаны ерөнхий прокурорын газар шийтгүүлсэн хүмүүсийг шилжүүлж авах талаар Хятадтай хоёр талын хэлэлцээрээр зөвшилцөх, гэрээлэх ажлыг хийж байна.

Дэлгэрэнгүйг

<http://ru.trend.az/regions/casia/kyrgyzstan/1616292.html>.

Бөхөн ахиад аюулд орлоо: Аврах уриалга

Баруун хойд Прикаспийн (ОХУ) хэцүү байдалд буй бөхөнгийн популяци хатуу ширүүн өвөл болон хулгайн ангийн улмаас олноороо үхэх аюулын өмнө ахин тулгараад байна. Бөхөнгийн тоо 10 жилийн туршид 95 % буурсан нь том туруутан амьтдын хувьд хамгийн эрчимтэй явагдсан хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн. Сүүлийн жилүүдэд зарим популяциудын хувьд тоо толгой тогтворжиж, Оросын Баруун Хойд Прикаспид ойролцоогоор 20000 орчим бөхөн үлдсэн нь энэ популяци хамгийн бага тоон дээр тогтворжсон нь юм.

Гэвч энэ өвөл Баруун Хойд Прикаспийн бөхөнгийн популяци зуд хэмээх байгалийн үзэгдлээс болж хүнд байдалд ороод байна. Мөсөн бүрхүүлтэй зузаан цасны улмаас бөхөнгүүд тэжээл олох, шилжиж явахад хэцүү болов. Хамгийн сүүлд Баруун Хойд Прикаспид 1998/1999 оны өвөл зуд болсон ба энэ үед бөхөнгийн тоо толгой 150 мянгаас 50 мянга хүртлээ буурах шалтгаан болсон гэж үздэг. «Халимагийн мэдээ» сонины 2010 оны 2-р сарын 12-ны дугаарт бөхөнгийн популяцийн хэмжээнд зудын нөлөөллийн зохих үнэлгээг хийгээгүй боловч одоо бөхөнгийн тоо аль хэдийн 8000 хүртлээ буурсан байж болох юм гэжээ. Энэ өвлийн нөхцөл байдал популяцийг энэ хэмжээнд буюу мөхөх хүртэл бууруулсан байх боломжыг үгүйсгэж болохгүй.

Одоо Баруун Хойд Прикаспид хулгайн ан ихсэж, махны хууль бус наймаа цэцэглэж байгааг хэлэх хэрэгтэй. Халимагийн бүгд найрамдах улсын энергийн хөгжил, хүрээлэн буй орчны хамгаалал, байгалийн нөөцийн яамны сайдын орлогч Юрий Каминов «нөхцөл байдал хяналтаас гарлаа. Яшкульск районд бөхөнгийн махны худалдаа явагдаж буй тухай мэдээлэл байна» хэмээн зарлав.

Их цасанд бөхөн хулгайн анчдаас зугтаж чадалгүй хялбархан олз болж байна. Казахстанд ийм нөхцөлд хулгайн анчид цасан дээр явагчыг ашигладаг байна.

Баруун Хойд Прикаспийн популяцийн ихэнх хэсэг байршдаг Халимагийн бүгд найрамдах улсын энергийн хөгжил, хүрээлэн буй орчны хамгаалал, байгалийн нөөцийн яамнаас бий болоод байгаа нөхцөлд ихээхэн санаа зовниж, «энэ бүрдээд буй нөхцөлд бид бөхөнгөө бүрмөсөн алдаж болохоор байна» гэдгийг тэмдэглэн тусламж хүсэн хандсан байна.

Хулгайн ан болон бөхөнгийн махны худалдааг Орос болон бөхөн тархсан бүх орнуудад хориглосон боловч одоогийн хуулиудыг хэрэглэхэд ихээхэн дутагдалтай нь мэдрэгдэж байна. Энэ нь ялангуяа Халимагийн хувьд санхүүжилт хүрэлцдэггүй нь Москвагаас бүс нутгууд руу амьтны аймгийг удирдах 2008 оны 1-р сард шилжүүлсэн санхүүжилттэй холбоотой. Энэ мөчөөс эхлэн Халимагийн бүгд найрамдах улсын нутаг дэвсгэр дээр биологийн төрөл зүйлийн хамгаалалт хариуцсан байцаагчдын тоог 30-аас 6 болтол бууруулсан. Өөрийнхөө хэмжээгээр Ирландаас хэд дахин том ойролцоогоор 75000 км² талбайтай Халимагийн бүгд найрамдах улсад эдгээр байцаагчид олон зүйл амьтдыг хамгаалах ёстой, байгаль хамгаалагчдын эдгээр бага тоо ихээхэн санаа зовнилыг бий болгож байна. Халимагийн бүгд найрамдах улс болон Астрахань мужийн захиргаанууд бөхөнгөө аврах үйлсэдээ туслахыг хүсэн хандивлагчдад ханджээ. Бөхөн хамгаалахын тулд улсын байцаагчдад тусалцаа үзүүлдэг нутгийн сайн дурынханы хөлс, илүү тоноглогдсон тээврийн хэрэгсэл худалдан авах, эргүүл хяналтын машины бензин худалдан авахад тэдэнд хөрөнгө шаардлагатай байна. Үүсээд буй нөхцлийн талаар нутгийн иргэдэд үзүүлэн, телевиз, радио ашиглан мэдээлж, тэдний дэмжлэгийг авахын тулд олон нийтийн мэдээллийн хэрэгсэлүүдтэй компанит ажлуудыг явуулах болно.

Доктор Алин Кюль
НЗХК, БХХ Нарийн бичгийн даргын газар
akuehl@cms.int



Зургийг Ю. Арсланова

2010 оны зудтай өвөл . Яшкульск үржүүлгийн газар, Халимаг.

Эрдэм шинжилгээний өгүүллэгүүд

Казахстанд бөхөнгийн нүүдэл шилжилтийн судалгаа

Цутер Ш.

Алтын-Дала байгаль хамгаалах санаачлага, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, steffen.zuther@acbk.kz; office@acbk.kz

Казахстаны нутаг дэвсгэр дээр хэрэгжиж буй томхон төслийн хүрээнд анх удаа бөхөнд сансрын дохиололтой хүзүүвч зүүсэн. Хүзүүвчны тусламжтай бөхөнгийн байршлыг өдөр бүр тодорхойлон тархац нутгийн хүрээнд уудам нутагт тэдгээрийн шилжилтийг хянах боломжтой юм. Үр дүнд авсан мэдээллүүд энэ зүйлийг хамгаалахад ихээхэн нэмэр оруулна.

2009 оны 10-р сард 3 долоо хоногийн туршид 20 бодгалийг барьж, хүзүүвчилсэн. Энэ нь Төв Казахстанд хээр, цөлийн экосистем, түүндэх түлхүүр зүйлүүдийг хамгаалахаар эрмэлзэж буй Алтын-Дала байгаль хамгаалах санаачлагын үйл ажиллагааны хэсэг юм. Төлөвлөж буй «Алтын Дала» улсын байгалийн нөөц газрын орчим болон Иргиз–Тургайн улсын нөөц газраас умар зүгт бетпакалинскийн популяцийн бөхөнгүүдийн гол байршил нутгуудад барилтыг хийсэн.



Зургийг Ш.Цутера

Бөхөнг тор луу шахаж хөөхөд мотоцикл ашиглав.

Хээрийн ажлыг эхлэхээс өмнө болон түүний явцад барих маш олон аргуудыг хэлэлцсэн ба энэ үед Монголын туршлага (БХОУС болон Биологийн хүрээлэн, *Бөхөнгийн мэдээ*-ний 4,6-р дугааруудыг харна уу) ялангуяа хөөх ба хүзүүвч зүүх хугацааг тодорхойлоход хамгийн ашигтай нь байсан. Энэ туршлага болон хээрийн багийн гишүүдийн хэлсэн санаан дээр үндэслэн амьтандаа аюулгүй, хамгийн үр дүнтэй аргыг боловсруулж, туршсан. Сүргийг илрүүлсэний дараагаар машин болон мотоциклээр түүнийг хөөж, сүргээс нэг бодгалийг мотоциклээр таслан, торийг газар хэвтэж байршуулж байгаад ойртох мөчид тороо босгон тор луу шахан хөөсөн. Энэ арга амьтныг «зөөлөн» барихыг баталгаажуулж, стресст бага оруулан хүзүүвчээ хурдан зүүх боломж олгосон.

Сайн сургалт, хангалттай хүн, техникийн ачаар бөхөнгийн стресийг хамгийн бага болтол багасгасан. Бөхөн хөөх дээд хугацааг 4-н минутаас хэтрэх ёсгүй байсан нь өмнөх ижил судалгаануудад ашигласанаас ч бага байв.



Зургийг А.Селемгареева

Хүзүүвчилсэний дараах бөхөнгийн шаргачин .



Зургийг Б.Исмакова

Бөхөн хүзүүвчлэх ажлын хээрийн баг.

Амьтны аймгийг хамгаалах албаны дарга Оркен Шаймуханбетовын удирдлага дор энэхүү ажилд 20 гаруй хүн «Охотзоопромтой» хамтран оролцлоо. Барих үед хоёр туршлагатай мотоциклчидыг оруулан «Охотзоопром» -ын улсын дөрвөн байцаагч шууд оролцсон. Бөхөнгийн сүргүүдийн байршлыг тодорхойлохын тулд эхнээсээ онгоц ашигласан харин дараагаар нь бөхөн барихдаа машин, мотоцикл ашигласан. Барилт хийхийнхээ өмнө амьтантай зөв, аюулгүй ажиллахын тулд Франкфуртын амьтны хүрээлэнгийн малын эмч –доктор Кристины Гайгерээр хэд хэдэн сургалтыг явуулж, эхний бөхөнгүүдийг барих үед хамтран оролцсон. Сургалтын объектод гэрийн ямааг ашиглав.

Бөхөнгүүд маш үргэмтгий, алс холоос зугтдаг учраас, энэ ажлын хамгийн хэцүү нь бөхөн барих байв

Хөөх хугацааны дээд хязгаар нь амьтан хэт багтархаас сэргийлж, хэрвээ заасан хугацаа хэтэрвэл хөөх оролдлогоо шууд зогсоох учиртай байсан. Дараачийн хүзүүвч зүүх хугацаа ч 4-5 минутаар хязгаарлагдаж байв. Энэ хугацааны дотор багийнхан биеийн хэмжилт, дулааныг авч, мөн жигнэн, цус, үснээс нь анализ хийхэд шаардлагатай дээж авч, хүзүүвчээ зүүсэн. Бүх ажиллагааг хурдан гүйцэтгэсэн нь бүх амьтдаа хэвийн тайван суллах нөхцөл болсон.

Тухайн төсөлд амьтны байршил тодорхойлоход зориулагдсан GPS бүхий GPS/Globalstar, координат дамжуулахад Globalstar сансрын системээр Казахстан дахь Алтын Далын байгаль хамгаалах санаачлага байгууллагын түнш Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг рүү дамжуулахад ашигласан хүзүүвч нь харьцангуй шинэ технологи болно. Өдөр болгон бүртгэж өдөрт нэг удаа хос координатуудыг дамжуулсанаар байнгын ажиглалт явуулах боломжтой болов.

Устюртэд бөхөнгийн шилжилтийг хиймэл дагуул ашиглан судлах төсөл эхэллээ

Ито Т.И.¹, Шинода М.¹, Есинов А.В.², Грачев Ю.А.³, Н. Сингх⁴, Милнер-Гулланд Э.Дж.⁴

¹ Тоттори их сургууль, ² Узбекистаны амьтан судлалын хүрээлэн, ³ Казахстаны амьтан судлалын хүрээлэн,

⁴ Лондонгийн эзэн хааны коллеж, ito@alrc.tottori-u.ac.jp

Устюртэд бөхөнгийн шилжилтийг сансрын хиймэл дагуул ашиглан судлах төсөл 2009 оны 11-р сард эхлэв. Сансрын хиймэл дагуул ашиглан судлах нь уудам зайд амьтны шилжилтийн экологийн болон байгаль хамгааллын судалгаанд чухал ач холбогдолтой хэрэглэхүүн юм. Үүний тусламжтайгаар нүүдлийн замууд, байршил нутгууд, амьдрах орчны сонголт, амьтдын шилжих замд буй саадыг тодорхойлох боломжтой болж байна. Бөхөн бол хол зайд шилждэг учраас сансрын дохиолол бүхий хүзүүвч ашиглан судалгаа явуулахад хамгийн тохиромжтой зүйлүүдийн нэг бөгөөд хэт цөөрсөн учраас хамгаалах шаардлагатай байна. Устюртийн популяци Узбекистан болон Казахстаны хил дагуу байрших учраас түүнийг хянах, хамгаалах, асуудлуудыг шийдэхэд чухал мөчид энэ төсөл ач холбогдолтой байх болно. Устюртийн экосистемийг хамгаалах, амьдрах орчны сонголт, бөхөнгийн шилжилтийн механизмуудыг ойлгоход төслийн үр дүн чухал байх болно. Түүнээс гадна, Монголд (*Saiga tatarica mongolica*) болон Бетпақдальд (дээр харна уу) сансрын хүзүүвч зүүсэн бөхөнгийн бусад популяциудтай харьцуулах, мөн цагаан зээр зэрэг хол нүүдлэдэг бусад зүйлүүдтэй харьцуулах мэдээллүүдийг авна.



Зураг 4. Есинова

Бөхөнгийн шаргачинд сансрын дохиололтой хүзүүвч зүүж байна.

Казахстанд устюртийн популяцийн тархцын өмнөд хэсэгт 2009 оны 11-р сарын 10-13 нд бөхөн барьж сансрын дохиололтой хүзүүвч зүүх ажлыг гүйцэтгэлээ. Бетпақдалийн популяцид сарын өмнө ашигласан бөхөн барих аргыг бид хэрэглэсэн. Бөхөн барихад бидэнд олон байгаль хамгаалагчид, нутгийн иргэд зэрэг 20 гаруй хүмүүс тусласан. Бид 10 бөхөн барихаар төлөвлөсөн. Гэвч хэд хэдэн сөрөг хүчин зүйлүүд болох мотоциклийн эвдрэл, бөхөнгийн нягтшил бага, цаг хугацаанд хязгаарлагдсан зэргээс болж зөвхөн 5 шаргачинг амжилттай хүзүүвчилсэн. Бид барих оролдлогоо 2010 онд давтан хийхээр тохиролцсон. Бид 8 хоногийн зайтайгаар бөхөнгийн байршлын мэдээг авахын тулд GPS-гүй Argos систем болон сансрын дамжуулагч (TAW-4310H, Telonics) ашигласан.



Зураг 5. Есинова

Бөхөн барих тор тогтоож байна.

Дамжуулагчид 2,5 жилийн туршид дохиолол дамжуулах болно.

Энэ төсөл Тотторигийн их сургуулийн цөлийн судалгааны эрдэм шинжилгээний төв (Япон), Казахстаны амьтан судлалын хүрээлэн, Казахстаны ой, агнуурын аж ахуйн хорооны «Охотзоопром», Узбекистаны амьтан судлалын хүрээлэн, Лондонгийн эзэн хааны коллежуудын (Их Британи) хамтын

ажиллагаа бөгөөд Японы боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны эрдэм шинжилгээний төслөөр санхүүжигдэж байна. Төсөл нь бөхөн хамгаалах салбарт урт хугацааны олон улсын хамтын ажиллагааны сайхан эхлэл бөгөөд Устюртийн тэгш өндөрлөгт ирээдүйн байгалийг хамгаалах чиглэлээр хийгдэж байгаа болон төлөвлөж буй арга хэмжээнүүдийн үр дүнгүүдийг шууд ашиглах болно.

Монгол бөхөнгийн янзаганы мэнд үлдэлтийн талаар ШИНЭ МЭДЭЭ

Бүүвэйбаатар Б.¹, Янг Дж.К.², Лхагвасүрэн Б.¹, Бергер Дж.^{3,4}, Файн А.⁵

¹ ШУА-ийн Биологийн хүрээлэн, Улаанбаатар, Монгол, buuveibaatar@gmail.com;

² Зэрлэг байгаль судлах хүрээлэн, Арката, АНУ; ³ Биологийн факультет, Монтанагийн их сургууль, Миссолина, АНУ; ⁴ Хээрийн суурин Northern Rockies, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, Монтанагийн их сургууль, Миссолина, АНУ; ⁵ Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, Улаанбаатар, Монголиа

Баруун Монголд бөхөнгийн төллөх хугацаа болон янзаганы мэнд үлдэлтийн онцлогийг үнэлэх чиглэлээр Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, Монголын ШУА хамтарсан хоёр жилийн төслийг 2008 оны 6-р сард эхлүүлсэн (Бөхөнгийн мэдээний 8-ыг харна уу). Энэ жил бид Шаргын нөөц газрын 2008 онд ажиллаж байсан газраа 6-р сарын 8-наас 21-ны хооронд бөхөнгийн янзага барих хээрийн ажлыг хийсэн. Анхны янзагыг 6-р сарын 12-нд барьсан нь өмнөх оныхоос 1 өдрийн өмнө байв.

Бид 40 янзага барьж VHF радиохүзүүвч бүгдэд нь зүүсэн. Тэдний 45 хувь нь ихэр байв. Эр болон эм янзагануудын хооронд биеийн жингийн үнэмшилтэй ялгаа ($t = 0,9$, $p = 0,3$) байсангүй. Энэ жилийн янзагануудын биеийн жин өнгөрсөн жилийнхээс жаахан илүү байсан (2008 он.: $2,69 \pm 0,36$ кг; 2009: $2,80 \pm 0,41$ кг; $t = 1,3$, $p = 0,1$).

Тухайн нутагт махчин амьтдаас шар үнэг хамгийн элбэг тааралдаж байсан. Судалгааны үед хүзүүвчилсэн 3 янзагыг үнэг, нэгийг махчин шувуу барьсан, харин нэг хүзүүвч эвдэрсэн байсан. Дахин 3 хүзүүвчилсэн янзага бидний хээрийн судалгаанаас хойш 2 долоо хоногийн дотор үхсэн. Эдгээр янзагануудыг мөн л махчид (хоёрыг нь үнэг, нэгийг нь махчин шувуу барьсан) идсэн байв. Түүнчлэн бид хүзүүвчлээгүй янзага руу махчин шувууд довтлох, үнэгнүүд янзага барих гэсэн 4 тохиолдлуудыг ажигласан.

2008 онд хүзүүвчилсэн янзагануудаас 21 нь амьд үлдсэн. Одоогоор 54 бөхөнгийн янзагыг ажиглаж байна (2009 онд 33 янзага хүзүүвчилсэн). Мониторингийг судалгааг байгаль хамгаалагчид хийж байгаа. Тэд Шаргын нөөц газарт мотоциклээр явж, хүзүүвчтэй янзагануудын дохиололыг долоо хоногт хоёр удаа авч байна.



Зургийг: Б. Чалсодорж

Шаргийн говьд бөхөнгийн шинэ төрсөн янзага.

Янзагануудын байршилыг тогтоох болон үхсэн янзагануудын сэг зэмийг олж хүзүүвчнүүдийг сэргээж байгаа. Бидний 2008 оны судалгаагаар анхныхаа өвлийг хүртэл 39 хүзүүвчилсэн янзаганаас 17 нь үхсэнийг тогтоосон. Өвлийн өмнөх үед мэнд үлдэх коэффициент 0,57 (0,42 – 0,72). 4 болон 5-р саруудын дунд үед үлдсэн хүзүүвчтэй янзагануудын байршилыг тодорхойлох дараагийн судалгааг хийсэн. Ингэхэд дахин хоёр янзага үхэж, хоёр нь дохиололоо өгөөгүй байна. 2008/2009 онуудын адилаар 2010 оны хавар болон намар үлдсэн 54 янзагануудын ажиглалтыг үргэлжлүүлэн хийх болно.

Хүснэгт 1. Бөхөнгийн шинэ төрсөн янзаганы биеийн жин (кг)

он	эр			эм		
	X±m	limit	n	X±m	limit	n
2008	2.79 ± 0.32	2.24 - 3.52	22	2.56 ± 0.38	1.95 - 3.36	18
2009	2.86 ± 0.43	2.32 - 3.83	23	2.74 ± 0.38	2.12 - 3.64	17
бүгд	2.82 ± 0.37	2.25 - 3.65	45	2.65 ± 0.38	2.02 - 3.45	35

Баруун Монголын

Их нууруудын хотгорын бөхөнгийн хамгаалал



Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас (ДБХС) 2007 онд МАВА сангийн дэмжлэгтэйгээр Монгол бөхөн хамгаалах төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

Бөхөнгийн популяцийг хуучин тархац нутгийн хүрээнд сэргээх, хууль эрхзүйн орчинг сайжруулах, нутгийн иргэдэд түшиглэсэн байгаль хамгаалах үйл ажиллагааг өрнүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах, оюутан сурагч, хүүхэд багачууд, нутгийн иргэдийн дунд сургалт сургалчилгаа явуулах зэрэг үйл ажиллагаа явуулж байна. Бөхөнгийн ач холбогдол, байгальд байх үнэ цэнийг ойлгуулах замаар ард овун ухаантай ажиллаж байна. 2007 онтой харьцуулахад бөхөнгийн тоо 8%-аар өссөн байна. Бөхөнгийн тархац нутаг Шаргын говиос урагш болон зүүн тийш, Дөргөний хүрэн талаас хойд зүгтээ тэлсэн. Байгаль хамгаалах хүсэл эрмэлзэлтэй нутгийн иргэдийг татан оролцуулах, аймгийн болон бүсийн хэмжээнд төрийн байгууллагуудтай хамтын харилцаагаа сайжруулах, эрдэмтэдтэй хамтран ажиллах зэрэг олон чухал асуудлуудыг шийдэх чиглэлээр ажиллаж дэлхий нийтийн өмнө Монголын хүлээсэн үүргийг биелүүлэхэд хувь нэмрээ оруулсан.

I. Хууль эрх зүй


Хууль бус агнуур, худалдаатай тэмцэх хөдөлгөөнт, шуурхай баг, мэргэшсэн байгаль хамгаалагч, орон нутгийн идэвхтэн байгаль хамгаалагч, идэвхтэн ард иргэдийн оролцоотой сүлжээг бий болгосон. Эдгээр байгаль хамгаалагчид нь бөхөнгийн биологи, байгаль хамгаалал, байгаль хамгаалах чиглэлийн бодлого, байгаль хамгаалах хууль тогтоомж, олон нийттэй харилцах, мэдээлэл цуглуулах арга зүйд суралцсан. «Бөхөн хамгаалах сүлжээ баг нь Монголын шилдэг бөгөөд хамгийн үр дүнтэй хууль сахиулах нэгж юм ...» гэж Байгаль орчин, аялал жуулчлалын яамны тэргүүн тэмдэглэсэн.

Байгаль орчны хууль, тогтоомж зөрчлийг бүртгэнхянан шалгах зорилготой, хянах зорилготой “Ирвэс” программ амжилттай ажиллаж, Говь-Алтай аймгийн хэмжээний хууль бус агнуур, худалдааны мэдээллийн сантай болсон ба мэдээллийн санд үндэслэн хууль бус агнуур ихээхэн гардаг бүс нутгуудийг тогтоон анхаарал хандуулж байна.

Ирвэс программ нь байгаль хамгаалах салбарт хууль зөрчигчдийг илрүүлэх, хянаж шалгах үр дүнтэй хэрэгсэл болсон төдийгүй мэдээллийн сан



Б.Чимэддорж
Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн
Монгол дахь хөтөлбөрийн газар, chimeddorj@wwf.mn



Зураг. Бөхөнгийн тархац нутаг дахь малчдын нөхөрлөл, бүлгүүдийн байршил

үүсгэсэнээр хууль сахиулах байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, үйл ажиллагааны уялдааг сайжруулахад тус болж байна.

II. Байгаль хамгаалах иргэдийн үйл ажиллагаа

Бөхөн хамгаалах, тогтвортой ашиглахад орон нутгийн нөхөрлөлүүд гол үүрэг гүйцэтгэдэг. Орон нутгийн идэвхтэнүүд байгаль хамгаалах нөхөрлөлийн талаарх суурь мэдээллийг ард иргэдэд дамжуулж, нөхөрлөл байгуулах чиглэлээр сонирхсон хүмүүс, иргэдэд хамтын оролцоо, хамтын ажиллагааны ач тусын талаар зөвлөгөө өгөн ажиллаж байна. Бөхөн тархсан хамгийн чухал нутгуудад нутгийн иргэдээс бүрдсэн 10 нөхөрлөлийг бий болгосон (Зургийг харна уу). Ард иргэдийн амьжиргааг сайжруулахад туслах, өөрөөр хэлбэл тэдэнд бүх талаар амьжиргаагаа сайжруулах, малынхаа чанарыг дээшлүүлэх, бэлчээрийн зохистой ашиглалтийг бий болгоход нь туслах замаар байгаль хамгаалах үйлсэд малчдын дэмжлэгийг авахад төслийн үндсэн санаа оршиж байгаа юм. Гэрийн малын тоо өссөнөөр хөрс, ургамалжилтын чанар муудаж, бэлчээр талхагдаж байгааг ихэнх хүмүүс хүлээн зөвшөөрдөг. Аз болоход нүүдэлчин малчдын ихэнх нь нөхцөл байдлаа ойлгож эхлэн, малынхаа тоог нэмэхээс илүүтэй чанарыг нэмэгдүүлэхэд анхаарлаа чиглүүлэхийг хүсэж байна; энэ нь бөхөн хамгаалах төсөлд шинэ боломжуудыг нээж байна.

III. Сургалт, сурталчилгаа

Сургууль, аймгийн боловсролын байгууллагатай хамтран ажилласнаар боловсролын үндэсний стандартыг нэвтрүүлэхэд зохих хувь нэмрээ рхуулц байна. Бөхөнгийн биологи, экологи, бөхөн хамгааллын ойлголтын түвшин нутгийн иргэдийн дунд өссөн бөгөөд үүнд орон нутгийн телевиз радиотой хамтран ажилласан үйл ажиллагаа нэмэр болсон. Байгаль хамгаалах чиглэлийн ном, хууль эрхзүйн гарын авлага зэргийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Боловсролын газартай хамтран орон нутгийн иргэд, оюутан сурагчдад түгээсэн. Төсөл хэрэгжиж байгаа нутгуудын сургуулиудад сурагчдын 10 клубуудыг байгуулан, ДБХС-ийн монгол дахь хөтөлбөрийн газар, Бөхөн хамгаалах сүлжээ багийн байгаль хамгаалагчид дэмжин ажилладаг. Бүх эко-клубууд төслийн санал боловсруулан жижиг хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

IV. Бөхөнгийн эврийн хууль бус худалдаа

Хулгайн ангийн тохиолдол болон хууль бус худалдааны талаар мэдээлсэн мэдээлэгчийг урамшуулах замаар хууль бус үйл ажиллагааны баримтуудыг илрүүлэхэд төсөл дэмжлэг байна. Бөхөн тархсан нутгуудад энэхүү зарчмыг иргэдэд маш сайн сурталчлан таниулсан. 13 бөхөн агнасан 4 хулгайн анчны талаар мэдээлэл өгсөн хоёр мэдээлэгчид тус бүр 1 сая төгрөгийн урамшуулал олгосон. Хулгайн антай тэмцэх бүлэг болон байцаагчдын сүлжээ аймгийн цагдаа болон байгаль хамгаалах агентлагуудтай хамтран ажиллаж 2008-2009 онуудад нийт 14 бөхөн агнасан 3 хулгайн ангийн тохиолдлыг илрүүлсэн. Бүх тохиолдлуудыг Говь-Алтай аймгийн шүүхээр шийдвэрлүүлсэн ба хэрэгтнүүд 3-5 жилийн хорих ял авчээ. 2006 онд гарсан алдарт 54 бөхөнгийн хэрэг Ховд аймгийн шүүхээр хэд хэдэн удаа буцаагдсаны эцэст



Зургаагч: Б.Цыгедорж

Хулгайн антай тэмцэг бүлэг жуух гардан авч байгаа нь

Хэрэг шийдэгдэж хэрэгтнүүд 3.6-аас 5 хүртэл жил шоронд суух ял оноосон байна.

V. Хамтран ажиллагч болон хандивлагчид

Энэ төсөлд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, бүсийн болон орон нутгийн удирдлагууд (аймаг, сум, багийн түвшинд), мөн олон улсын байгууллагуудтай (ШОУХА, ГТХАН ба НҮБХХ) нягт хамтран ажилладаг. Малчид, сурагчид, багш нартай үр бүтээлтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх нь хамгийн чухал юм. Төсөл өөрийн мэдээллээ бөхөн хамгаалах эвслийн интернет хуудас дээр <http://www.saiga-conservation.com> байршуулдаг. Бөхөн, түүний амьдрах орчныг Монголд болон олон улсын түвшинд хамгаалахад чухал хувь нэмэр оруулж санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа MAVA санд төслийн багийнхан талархалаа илэрхийлж байна.

Бөхөнгийн тархацыг зураглахад нутгийн иргэдийн мэдлэгийг ашиглаж болох уу?

Леон Дж.¹, Сингх Н.Дж.¹, Арылов Ю.Н.², Обгенова О.Б.³, Милнер-Гулланд Э.Дж.¹

¹Лондонгийн Эзэн хааны коллеж, jenny.leon08@imperial.ac.uk; ²Халимагийн зэрлэг амьтдын төв ; ³ Халимагийн «экологийн төслүүдийн төв»

Нутгийн иргэд ихэнхдээ тухайн газар орон нутгийнхаа ургамал амьтдын экологийн талаар өргөн мэдлэгтэй байдаг учраас мэдлэг дээр тулгуурлан шаардлагатай зүйлд ашиглаж болно. Бөхөнгийн өнөөгийн тархацыг зураглах зорилготойгоор Халимагт бид судалгаа хийсэн бөгөөд энэ нь урьд өмнө хийгдэж байгаагүй ажил юм. Бид мөн тодорхойлон зурсан тархацын хүрээнд хүмүүсийн мэдээлсэн мэдээлэлд нөлөөлөх хүчин зүйлүүдийг судалсан. Судалгааг 2009 оны зун хийсэн. Бид хүмүүсээс өөрсдийнх нь амьдардаг нутгуудад бөхөн харсан уу, аль улиралд бөхөн харав, сүүлчийн 12 сарын хугацаанд бөхөн харав уу? Тухайн газарт бөхөн байршихад ямар хүчин зүйлүүд нөлөөлж байгаа талаар асуусан. Асуулга судалгаанд бид суурин газарт амьдардаг хүнээс бус аль болох алс хол өөрсдийн аж ахуйтай амьдардаг хүмүүсээс асуухыг хичээсэн учир нь

газрынхнаас илүү байсан. Бөхөн харсан хүмүүсийн мэдээлэл шалтгаалах гурван хүчин зүйл байна: 1) бөхөн байх ёстой. Энэ нь ургамалжилт, ус зэрэг биологийн хүчин зүйлүүдээс шалтгаална гэж бид таамаглаж байна. 2) хэрвээ тэнд бөхөн байгаа бол ажиглагч түүнийг харсан байх ёстой. Энэ нь тухайн нутагт хүмүүсийн амьдарч байгаа хугацаа, тал хээр лүү явах очих давтамж, хоногийн цаг хугацаа, ашиглаж буй тээврийн хэрэгслийн төрөл зэргээс хамаарна гэж бид таамаглаж байна. 3) бөхөн харсаныгаа тэд бидэнд мэдээлэх ёстой. Энэ нь хүмүүс шударга байхыг хүсэж байна уу гэдгээс, магадгүй тэд хулгайн антай хийдэг байхаар болно, хамаарна гэж бид таамаглаж байна. Халимагийн бөхөнгийн тархацын өмнөх үнэлгээ болон шинжээчдийн бодолтой судлаж байгаа тархацаа бид харьцуулсан.

Хуучин тархацтай нь (Луценика & Стручков, 2001) харьцуулахад халимагт түүний хэмжээ нэлээд багассаныг харуулсан. Гэвч нутгийн шинжээч (Х. Манжиев) тархац арай том болохыг өгүүлсэн (зур. 1,2).

Бөхөнтэй тааралдах нутаг, цаг хугацаа зэрэг үзүүлэлтээр улирлын ялгаа гараагүй. Бөхөнгүүд улирлаас хамаарсан хол нүүдэл хийлгүй тусгай хамгаалалттай нутгийн эргэн тойронд аль ч улиралд тэмдэглэгдэж болохыг энэ нь гэрчилж байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН) гадна талд бүтэн жилийн туршид бөхөнгийн хамгааллыг зохион байгуулах шаардлагатай гэдэг үүднээсээ энэ нь чухал үр дүн.


Сүүлчийн 12 сарынхтай харьцуулахад өнгөрсөн хугацаанд тухайн нутагт бөхөн харсан хүмүүсийн мэдээлэлд маш олон янзын хүчин зүйлүүд нөлөөлсөн байна. Өнгөрсөн хугацаанд бөхөнтэй тааралдаж байсан хүмүүсийн өгсөн мэдээлэлд нөлөөлөх гол хүчин зүйлүүд бол нэг газартаа хэр удаан амьдарсан болох, хур тунадасны хэмжээ (бороо бага орох тусам тухайн нутагт бөхөнтэй илүү тааралдаж байсан), ойролцоо байрлах усны эх үүсвэрийн хүртээмж (ус ойр байх тусмаа бөхөн үзэгдэх магадлал илүүтэй) байв. Өмнө нь таамаглаж байсны адил бөхөнгийн өмнөх тархацад амьдрах орчны тохиромжтой байдал гэсэн хүчин зүйл голлон нөлөөлж байсан нь үүнээс харагдаж байна.

Гэвч сүүлийн 12 сарын хугацаанд бөхөнгийн тухай авсан мэдээлэлд нөлөөлөх ганц хүчин зүйл бол хүний нөлөө өөрөөр хэлбэл сүүлийн газрын орчин суурьил


Бусад сууринд амьдардаг хүмүүсээс Яшкулийн суурингийн иргэдээс авах мэдээлэл илүү магадлалтай, Комсомольскийн иргэдээс авах мэдээлэл арай бага магадлалтай байсан. Энэ нь нутаг дэвсгэрийн ялгаатай холбоотой байж болох ч зарим газруудад хүмүүс бөхөн байгаа тухай ярихыг хүсэхгүй байгаагын үзүүлэлт ч байж болно.

Хүмүүсээс авсан мэдээлэл хэр магадлалтай вэ ? гэдгийг тодорхойлох өөр арга бол тодорхой бүсээс авсан мэдээлэлүүд хэр зэрэг ялгаатай байна гэдгийг харах явдал, ойролцоо амьдардаг хүмүүс төстэй мэдээлэлүүдийг өгөх болно гэж үзэх. Халхутт суурингаас авсан мэдээлэлүүд хоорондоо маш их ялгаатай байсан, Эрденовск суурингийн иргэдийнх ч мөн мэдээлэл янз бүр байв. Магадгүй энэ нь эдгээр бүсэд хулгайн ан маш их явагддаг бүс гэдэгтэй ч холбоотой.

Хулгайн ан, усны хүрэлцээ бөхөнгийн тархацад одоогоор гол нөлөөтэй гэж нутгийн иргэд ярьж байна. Үнэн хэрэг дээрээ Халимагт тунадасны хэмжээ нэмэгдсэн, харин худаг мэтийн усны эх үүсвэрүүд эвдэрсэн учир усны хүрэлцээ багассан. Тунадасны хэмжээ, усны хүрэлцээ гэсэн ойлголтуудыг зэрлэг болон гэрийн амьтдын хувьд хязгаарлагч хүчин зүйлүүдийн тухай ярихдаа ялгах нь чухлыг өгүүлж байна.



Зураг 1. Асуулга судалгаагаар тодруулсан бөхөнгийн тархацын хил болон тэмдэглэсэн цэгүүд, мөн шинжээчийн тодорхойлсон хил (Черные земли ТХГН-н ахлах эрдэм шинжилгээний ажилтан Х.Манжиевынхаар)



Зураг 2. Бөхөнгийн 1950-1965 оны болон харьцангуй саяхны (Луценика & Стручков, 2001) тархацын зураг

Энэ судалгаа бөхөнгийн өнөөгийн тархац болон түүнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг тодорхойлоход тус болсон. Түүнчлэн нутгийн иргэдээс авч байгаа мэдээллийн нарийвчлалын асуудлыг ч хөндсөн. Бөхөнгийн

экологийн чиглэлээр мэдээлэл цуглуулахад нутгийн иргэдийн оролцоотой явуулах мониторингийг сайжруулах, байгаль хамгаалын арга хэмжээг үр дүнтэй явуулахад энэ маш чухал.

«Европийн хээрийн ховор амьтны төвд» байгаа бөхөнгийн эвэртэй шаргачин

Миноранский В.А.

«Хээрийн амьд байгаль» нийгэмлэг, Өмнөд холбоотны их сургууль

Бөхөн нь илэрхий бэлгийн хоёрдогч шинж тэмдэгтэй амьтан. Шаргачингууд оононоос эвэргүй зэрэг хэд хэдэн шинжээр ялгаатай. Оононы гавлын ясны хэсэгт эвэр байдаг бол шаргачинд гол төлөв ясан ургацаг байрлах бөгөөд түүнээс заримдаа маш ховор тохиолдолд эвэр ургадаг. Баруун-хойд Прикаспийд эвэртэй шаргачин тааралдах давтамж 10000 бодгальд 2-3 байдаг. «Европийн хээрийн ховор амьтны төвд» нэг эвэртэй шаргачин бий.

Төвийг 2003 онд ОХУ-ын Ростов мужийн Кундрюченский тосгонд байгуулсан. Төвд байгаа олон зүйл амьтдаас хамгийн олон тоотой нь бөхөн юм. Олон жил бөхөн энэ төвд амжилттай үржиж өсөж байна. Одоогоор төвд 47 бөхөн бий (харна уу. *Бөхөнгийн мэдээ*, дуг. 3).

Эвэр ургасан шаргачин төвд 2005 оны 5-р сард төрсөн. Тэрээр 2007 онд янзага гаргасан боловч 2008 тэрээр ганцаараа сувай үлдсэн. Эвэртэй шаргачин ихэнхдээ оононуудаас зугтахыг хичээдэг болохыг ажиглалтаар тогтоосон. Энэ шаргачин 2009 онд бусад шаргачинтай харьцуулбал үр төл оройтож өгсөн боловч янзага их бие султэй, хоёр сартайдаа үхсэн.

Энэ шаргачингийн эвэр оононынхоос эрс ялгаатай (зургийг харна уу). Эвэр нь тэгш хэмгүй, баруун эврийн урт нь 11 см, харьцангуй шулуун, ихэнх хэсэг муу хөгжилтэй, харин орой нь урагш болон гадагшаагаа мэдэгдэм гажсан. Зүүн эвэр толгойн хэсгээс бараг хэвтээ чиглэлд хажуу



Зургаа С. В. Толмеевой

Эвэртэй бөхөнгийн шаргачин .

тийш гарч урагш болсоноо дотогшоогоо дугуйрч мушгирсанаа түүний үзүүр нь дээш болон урагшаа болсон байна. Энэ эврийн урт 14 см, угийн хэсгийн диаметр 1,8 см. Эврийн угийн хэсгийн өнгө бусад хэсгээсээ бараан. Энэ шаргачингийн үржлийн мэдээллийг ашиглан бөхөнгийн шаргачинд эвэр ургах нь бие организм дэхь гормоны хэвийн бус үйл ажиллагаатай холбоотой гэж таамаглаж болно

«Яшкульск бөхөн үржүүлгийн төвийн» бэлчээрийн агроболовсруулалт

В.Н.Федосов

«Халимагийн бүгд найрамдах улсын зэрлэг амьтны төв»

Халимагийн бүгд найрамдах улсын Яшкульск районд 2002 оноос хагас зэрлэг нөхцөлд бөхөн үржүүлэх төв ажиллаж байна. Заримдаг цөлийн 800 га газарт үржүүлгийн төвийг байршуулсан. Чийг хомсдолтой нөхцөлд ядмаг хөрсөнд сийрэг ургамалжилт ургадаг (тусгаг бүрхэц 50-60%).

Үржүүлгийн төвийн хөрс нэлээд хүнд механик бүрдэлтэй, их нягт хатуу, давсархаг учир агаарын чийг бүрэн шингэхэд саад болдог. Зонхилох зүйл ургамал нь шарилж. Эдгээр нөхцлүүд бөхөнд сайн тохирдог. Төмөр метал тороор хашаалсан 62 га талбайд 68 бодгаль бүхий сүрэг байдаг (харна уу. *Бөхөнгийн мэдээ*, дуг. 2).

Хэдийгээр бэлчээрийг ашигласан хугацаа ихгүй ч

(2003 оноос) хязгаарлагдмал талбайд бүтэн жилийн турш бөхөн бэлчих учир ургамалжилтанд өөрчлөлт гарахад хүргэснийг үржүүлгийн газрын хашааны гадна болон дотор талын хөрсөн дээрх бүрхэвчийг харьцуулахад илт харагдана. Үржүүлгийн газрын гадна талын гэрийн мал бэлчдэг нутгуудад шарилжин бүрхэвч хэвээр байна. Намар өвлийн улиралд үржүүлгийн газарт бөхөнгийн нэмэлт тэжээлд зардал их гарч байна.

Халимагт бэлчээрлэж байгаа олон тооны мал, ялангуяа хонь ХХ-р зууны хоёрдугаар хагаст бэлчээрийг доройтуулж, тэжээлийн чанараараа үнэтэй олон тооны ургамал устгах, цөлжих үйл явцыг түргэсгэхэд хүргэсэн.

Үүссэн асуудлыг шийдэхээр «Халимагийн бүгд найрамдах улсын зэрлэг амьтны төв» (Яшкульскийн үржүүлгийн газар багтдаг) болон Вильямсийн нэрэмжит тэжээлийн институт ВНИИ бэлчээрийн бүтээмжийг дээшлүүлэх чиглэлээр ажиллаж байна. Цөлийн тэжээлийн ургамлын туршилтын газрыг байгуулж, нутгийн хамгийн сайн чанарын ургамлууд болон Дундад Ази, бусад бүсээс авчирсан ургамлуудыг туршин үзэж байна. «Яшкульский» үржүүлгийн газрын хашсан талбайд зэдэргэнийн (янз бүрийн газарзүйн хэлбэрүүд) болон бударганын хагас сөөгөнцөр дорнод болон жижиг навчит, тэсэг, хар заг, элсний овъёос зэрэг зүйлүүдийн туршилтын тариалалт хийсэн. Гэвч зөөн авчирсан ургамлуудын байгалийн тархалт нутгийн нөхцлөөс Халимагийн хөрс нэлээд ялгаатай боловч эдгээр ургамлуудын ихэнх амжилттай нутагшин ургасан зохиомол фитоценозууд нэлээд өндөр бүтээмжтэй байна. Туршилтын ургамлуудыг бөхөнгүүд сайн идэж байна.

Туршилтын ургамлуудаас 2007 болон 2008 оны намар үр цуглуулж эх ургамлуудын талбайг томсгохоор



Зургийг Н.Арысолов

«Яшкульск» үржүүлгийн газрын туршилтын талбайд.

ашигласан. 2008 оны хавар бөхөн түр байршаагүй нэгэн хашаандаа тэсэгийн үр суулгасан. Цаашдаа үнэтэй тэжээлийн ургамлуудын суулгац, үйлдвэрлэлийн тариалалтыг өргөтгөх санаатай байна.

Аскания-Новагийн шинэ нээлт

Миноранский В.А.

«Хээрийн амьд байгаль» нийгэмлэг, Өмнөд холбоотны их сургууль

Москвэд болсон биологич, агнуур зүйчдийн олон улсын ХХХХ-р конгрессийн хүрээнд (2009 оны 8-р сар) амьтан үржүүлгийн янз бүрийн газруудын хооронд туршлага солилцох, уялдааг сайжруулах зөвлөмж гарсан. Харилцан айлчлалын гэрээнд тохирсоны дагуу 2009 оны 9-р сарын 20-23 нд Ростовын төлөөлөгчид Украинд ЮНЕСКО-гийн «Аскания-Нова» шим мандлын дархан газарт зочиллоо. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд «Хээрийн амьд байгаль» нийгэмлэг, «Ростовский» шим мандлын дархан газар, «Донской» морин завод, Ростов мужийн амьтны аймаг, усны биологийн нөөцийг ашиглах хамгаалах хэлтэсээс төлөөлсөн хүмүүс оролцов.



Зургийг Л. В. Клеуц

Аскания-Нова дархан газрыг үндэслэгч Ф.Фальц-Фейну зориулан бүтээж буй хөшөөний дэргэд

Дархан газрын олон жилийн түүх, олон үеийн хүмүүсийн хөдөлмөр зүтгэл, асар том хашаалсан талбайн бараг байгалийнхаа нөхцөлд буй олон зүйл амьтад «Аскания-Нова» дархан газрыг олон тооны эрдэмтэд, байгаль судлаачид, жуулчидыг

(энэ жилд дархан газарт 126 мянга гаруй хүн зочилжээ) өөртөө татсан маш өвөрмөц газар болгож чаджээ.

Ургамал болон амьтны олон янз байдал, эртний зам харгуй дээрх хуучны худаг, скиф болон эртний бусад нүүдэлчдийн үлдээсэн 17 хүн чулуун хөшөөнүүд энэ бүгд хүмүүсийн сонирхлыг татна.

«Аскания-Нова»-д биднийг зочилох үед хашаанд 300 орчим бөхөн байсны 70 нь 2009 онд төрсөн янзага байв. Амьтдын ихэнх хэсэг нэг сүргээр байв. Тал хээрт хааяа л тусдаа салсан бодгалиуд эсвэл жижиг сүргүүд тааралдаж байсан. Байгаль дээрээ бөхөн ямар үргэмтгий, болгоомжтой байдгийг мэдэх бид дархан газрын амьтад хүмүүсийг өөртөө хэр ойртуулж чадахыг сонирхлоо. Дархан газрын захирал Виктор Гавриленко бидэнтэй хамт явж «Нива» машинаар бөхөнгийн сүрэгт 25-40 м ойртож очиж чадсан юм. Энэ нь бидэнд амьтныг ойрхоноос ажиглах боломж олгосон юм.

Ажилчид бидэнд дархан газрынхаа бүх талын үйл ажиллагааг танилцуулж, хийж буй судалгааныхаа ажлын олон талыг харуулж, бидний бүх асуултанд хариулт өгсөн. Ростовийн нөхөд ч бөхөн, тоодог болон бусад зүйл амьтдыг тэжээвэр нөхцөлд үржүүлэх өөрсдийнхөө хуримтлуусан туршлагаас хуваалцлаа. Байгаль хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт, тал хээрийн дархан газрын хамгааллын хэцүү асуудлуудаа бид хэлэлцлээ. Бидэнд мөн ойролцоо байрлах Украины амьтан үржүүлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнд зочлох боломж олдсон юм. Олон жил энэ байгууллага дархан газартай нягт хамт ажиллаж, судалгаа шинжилгээ явуулахад нь тусалдаг байна.

«Аскания-Нова» болон «Ростовский» шим мандлын дархан газруудын хооронд хамтын ажиллагаа, амьтан солилцох, хамтын бүтээл, экологийн боловсрол, аялал жуулчлал, байгаль хамгааллыг хөгжүүлэхээр арга хэмжээ явуулахад бэлтгэх тухай зөвшилцөл байгуулсан. Энэ нь ялангуяа биологийн төрөл зүйлийг хамгаалах олон улсын жил болгон

2010 оныг Нэгдсэн үндэсний байгуулагийн шийдвэрээр бүх улс орнууд тэмдэглэж байгаа үед чухал юм.

Бид Аскания –Новагийн төлөөлөгчдийг Донийн нутагт Ростовийн шим мандлын дархан газрыг боломжтой цагтаа ирж үзэхийг урилаа. Бидний урилгыг талархан хүлээж авсан учир бид Украинаас манай зочдыг мэдээж 2010 оны хавар хүлээж авахад бэлдэх болно. Энэ үед бөхөн үржүүлгийн төвүүдийн олон улсын нэгдэлийг байгуулах төслийг бэлтгэж, нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах төслийн нарийн бичгийн газар болон үндэсний бүтцүүдэд танилцуулах ажил бий. «Хээрийн амьд байгаль» нийгэмлэг энэ нэгдлийн идэвхтэй гишүүн болж болох бөгөөд үүний тулд Ростовын шим мандлын дархан газартай зэргэлдээ Маныч-Гудило нуурын эрэг дээр ахин байгуулж

байгаа үржүүлгийн газрын хашааг өргөтгөх, зохион байгуулах чиглэлээр Ростов мужийн захиргаанд нэмэлт тусламж шаардлагатай байна.

Манай оронд бөхөн ховордоогүй байсан 60-аад онд Астраханск мужид амжилттай ажиллаж байсантай төстэй бөхөнгийн биологийн чиглэлийн тусгай лабораторийг байгуулах нь чухал. Энэ лаборатори бөхөн үржүүлэх технологийг сайжруулах асуудлаар (зохиомолоор хээлтүүлэх хүртэл) ажиллах юм. Түүний судалгаа шинжилгээг амжилттай төлөвлөхдөө «Аскания-Нова» дархан газар Украины амьтан үржүүлгийн судалгаа шинжилгээний хүрээлэнтэй хамтын үйл ажиллагааны туршлагыг ашиглаж болно.

Зурвалж С. В. Тонченко



Бөхөнгийн сүрэг.

Төслүүдийн тойм

Бөхөн хамгаалах эвслийн жижиг төслийн хөтөлбөрийн 2009 оны ялагч-төслүүд



БХОУС болон ЗАХАОУЗ байгууллагууд бөхөн хамгаалах эвслийн жижиг төслийн хөтөлбөрийг 2009 онд дэмжсэн нь бөхөн тархсан орнуудад бөхөнгийн 4 төслийг санхүүжүүлэх боломж бидэнд олголоо. 2000 хүртлэх долларийн санхүүгтэй бие даасан төслүүдийг санхүүжүүлэх замаар зэрлэг байгаль дээр бөхөн хамгаалах чиглэлийн үйл ажиллагааг хөтөлбөр дэмждэг. Цаг үеэ олсон болон практик шаардлагатай гэж хүлээн зөвшөөрсөн заалтуудад бодит өөрчлөлт оруулж бөхөн хамгаалах харилцан ойлголцлын тунхаглалын дунд хугацааны олон улсын ажлын хөтөлбөрийн биелэлтэд зохих нэмрээ эдгээр жижиг төслүүд оруулах ёстой.

Энэ хандлага түүнчлэн хүсэгчийн өргөдөл, олон улсын аудитыг оруулан олон нийтэд бөхөн хамгаалах харилцан ойлголцлын тунхаглалын тухай мэдээллийг түгээдэг. Энэ уралдааны зорилго бол орон нутагт бөхөнгийн хамгаалалд чиглэсэн дэмжлэгийн системийг гаргаж ирэх юм. Өөрийнхөө ажилд томоохон байгуулагуудаас олон улсын санхүүгийн дэмжлэг авах боломж байдаггүй хүмүүст энэ уралдаан чиглэсэн. Өмнөх ялагчдаа бид бөхөн хамгаалах гэр бүлд нэгдэнэ гэж итгэн ажлаа үргэлжлүүлэх боломж, нөөц олоход туслах бөгөөд байнгын сүлжээний дэмжлэгийг үзүүлнэ.

Төслүүдийг шалгаруулахдаа бөхөн хамгаалах эвсэл 4 гол шалгуурыг барьж тус бүрээр зохион байгуулах хорооны гишүүд үнэлэн эцэст нь эдгээр үнэлгээн дээрээ суурилан хамгийн өндөр оноо авсан төслийг шалгаруулдаг. Энэ жил байгаль хамгаалах янз бүрийн сэдэв, газарзүйн бүсүүдийг төлөөлсөн 4 сайн төслийг бид шалгаруулсан.



Анатолий Хлуднев, ОХУ. Астраханск муж, «Степной» нөөц газрын захирал. Энэ нөөц газар төллөх үеийн 10000 гаруй бөхөнгийн хамгаалалд томоохон ач холбогдолтой. «Степной» нөөц газар нь «Черные земли» дархан газартай хиллэх бөгөөд хамтдаа хулгайн ангаас болж хэцүүдээд байгаа бөхөнгийн популяцийн хамгааллыг хангадаг.

Анатолий бол Оросын армийн чөлөөнд гарсан дэд хурандаа бөгөөд түүний жижигхэн үнэнч багийнхан ялангуяа хамгийн анхаарах ёстой цаг үед нь бүтэн хоногийн туршид бөхөнгийн хамгааллыг хангадаг. Нөөц газартаа өөрийн гэсэн барилгагүй учир машин дотроо ч унтан ажилладаг. Анатолий өөрийн төслийн мөнгийг автомашиндаа зориулж ГСМ авахад ашиглах болно. Тэдний олж авах боломжтой бензины тоо хэмжээ нь хамгаалалтад зарцуулах цаг хугацаагаа нэмэгдүүлж эргүүл хяналтын үр дүнтэй байдалтай шууд холбоотой,

гэхдээ үүний тулд санхүүжилт олох нэлээд хүндрэлтэй. Байгаль дээр бөхөн хамгаалахад түүний ажил туслана гэдэгт итгэлтэй байгаа болохоор бид Анатолийг дэмжсэн. Оросын популяци хулгайн анд их өртдөг учраас ийм ажил маш их шаардлагатай («Степной» нөөц газарт хулгайн антай амжилттай тэмцэж байгаа тухай мэдээллийг энэ дугаарын мэдээ гэсэн бүлэгт харна уу).



Гуйхон Цзын 2008 оны 8-р сараас БХОУС-ийн Хятадын хөтөлбөрийн ажилтан болсон бөгөөд зэрлэг байгалийн зүйлсийн худалдааг судлах салбарт ажилладаг. Үүнээс өмнө Хятадын байгаль хамгаалах улсын байгууллагад 15 жил ажилласан. Гуанчжоу, гол худалдааны төвд зэрлэг байгалийн зүйлсийн хууль бус худалдаанд түүний ажил чиглэж байсан. Тэрээр голлох сонирхогч талуудыг (эмнэлгийн ажилтнууд, бизнесийнхэн, олон нийт) татан оруулах, мониторинг, сургалтыг хариуцдаг байв.

Гуйхоны авсан төсөл бөхөнгийн эврийн худалдааны гол цэг Гуанчжоу дахь уламжлалт хятадын анагаахын Кингпин зах дээрх бөхөнгийн эврийн худалдааны судалгааг явуулахад ашиглагдах болно. Тэрээр энэ зах дээр боловсролын компани ажлыг зохион байгуулж, бөхөн хамгаалах болон хууль тогтоомжийн тухай сонирхсон талуудад мэдээлэх, хууль сахиулах үйл ажиллагааг явуулахад нь туслахын тулд Гуанчжоугийн ойн аж ахуйн удирдлагад тайлангаа хүлээлгэх зэрэг ажлуудыг хийнэ. Хэрвээ бид бөхөндөө тогтвортой ирээдүйг бий болгохыг хүсч байгаа юм бол бөхөн хамгаалахад хэрэглэгчдийн анхаарлыг илүүтэй хандуулах шаардлагатай байгаа учир Гуйхоныг бид дэмжсэн.



Вера Воронова – Карагандинскийн улсын их сургуулийн оюутан, Карагандинскийн экомүзейн экологийн боловсролын төслийн техникийн туслах. Тэрээр шувуу судлаач, шувуудын экологи, хамгааллын чиглэлээр сайн дурын ажилтан, түүнчлэн сургууль дээрээ шувуу судлаачдын клуб

байгуулахад оролцсон, Тянь-Шанд хээрийн баазад эрдэм шинжилгээний туслахаар ажиллаж байсан.

Верагийн авсан төсөл нь бөхөнгийн тухай мэдээллийн самбарыг бий болгох, Карагандинск мужид энэ зүйлийн хамгааллын тухай хэвлэл бэлтгэх, экомүзейн вебсайт болон орон нутгийн сургуулиудад зориулсан сургалтын материал бэлтгэхэд ашиглагдах юм. Карагандинск муж бол зуны улиралд бетпакалинскийн популяцийн байрших хамгийн чухал нутаг бөгөөд энд ухуулга сурталчилгааны ажил хангалттай хийгддэггүй учраас бид энэ төслийг дэмжсэн. Түүнчлэн энэ төсөл Верад бусад бүс нутагт хийгдсэн бидний өмнөх туршлагауудыг ашиглан бөхөн хамгаалагч талуудын нутгийн сүлжээг байгуулахад нь туслах байх гэж бид итгэж байгаа.



Артур Нуридджанов Узбекистаны бүгд найрамдах улсын биоконтрольд ажилладаг. Тэрээр 2008 онд Арал тэнгист байрлах өнөөгийн Возрождения арал дээр экологийн аудитыг хийсэн. Энэ судалгааны үр дүнгүүдийг *Бөхөнгийн мэдээ №9*, www.saiga-conservation.com хэвлүүлсэн.

Зөвлөлт засгийн үед энд хаалттай цэргийн бааз байрлаж байгаад зөвлөлт засаг задарсаны дараагаар энэ бааз хаягдсан. Арлыг 2007 онд хүмүүст ахин нээлттэй болгосон боловч ихэнх хүмүүс хаягдсан барилгуудыг тонох, үргэмтгий бус амьтдыг хармагцаа хууль бусаар агнаж эхэлсэн.

Нефтийн компанийн захиалгаар Артурын хийсэн аудитаар бөхөн нутагшсан сүрэг бүхий хагас арал хээрийн экосистемийн олон янз байдлынхаа үүднээс үнэ цэнэтэй байгаа боловч экологийн нөхцөл байдал эрчимтэй муудаж байгааг харуулсан.

Энэ төсөл Артурт Возрождения хагас арал дээрх бөхөнгийн тархац, тоо толгойг судлах ажлыг үргэлжлүүлэхэд нь туслах болно. Одоохондоо арай хожимдоогүй байгаа дээр нь хагас арал дээр тусгай хамгаалалтай бүс байгуулах санааг ажил болгоход тэрээр мэдээлэлээ ашиглах болно. Бөхөн болон хээрийн бусад зүйлүүдийн хамгаалалд энэ нутаг чухал байж болох боломжтой боловч нөхцөл байдал хүнд байгаа учир энэ төслийг яаралтай гэж үзэн Артурыг бид дэмжсэн.

Бид өөрсдийнхөө ялагчдаар бахархахын зэрэгцээ эдгээр төслүүдийг дэмжих боломж бидэнд олгосон БХОУС ба ЗАХАОУЗ –нд талархаж байна.


Э.Дж. Милнер-Гулланд, e.j.milner-gulland@imperial.ac.uk

Монгол орны томоохон хөхтөн амьтдын хамгааллын шинэ хандлага

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар (ДБХС) 2009 оны 10-р сард МАВА-ийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “монгол бөхөнгийн *Saiga tatarica mongolica* агаарын тооллого” төслийг эхэлсэн. Монгол орны томоохон хөхтөн амьтдын тооллогын стандарт арга зүйд агаарын тооллогыг хэрэглэх, байгаль хамгаалах арга хэмжээг үр дүнтэй болгох заавал хийгдэх хэрэгсэл болгоход энэ төслийн гол зорилго оршсон. Бид дэд төслийн хүрээнд бөхөнгийн судалгаа явуулах зохион байгуулалтаас

эхэлсэн. Монгол бөхөнгийн популяцийн үнэлгээний найдвартай үр дүнтэй аргыг бий болгох, популяцийг хянахад үр дүнтэй хэрэгсэл гаргах нь энэ төслийн зорилго байв. Монгол бөхөнгийн агаарын тооллогыг 2010 оны намар хийхээр төлөвлөж байгаа. Онгоцны сонголт, судалгаа явуулах нутаг зэргийг тооцон бид тооллогын бүх техникийн болон арга зүйн талын ажлуудыг хийсэн, нислэгийн багийн бэлтгэл семинар, сургалтыг явуулсан, тооллогын материалуудыг бэлтгэсэн.

Шинэ хэвлэлүүд



Смирин В.М.



Европ болон Умард азийн хээрийн амьтдын хөрөг зургууд. Шинжлэх ухаан ба соёл урлаг- экологийн боловсролд / Зохиогчид. А.И. Олексенко, А.В. Зименко, П.П. Дмитриев, Е.В. Зубчанинова. - М.: Зэрлэг амьтан хамгаалах төвийн хэвлэлийн газар, 2008. - 92 х., зур.

Нэрт амьтан судлаач, зураач, байгаль шинжээч В.М. Смириний шинэ бүтээл сурах бичиг болон сэтгэлийн ном болж хээрийн бүсийн оршин суугчид, сурагчид, оюутнууд, багш нар, экологич, байгаль дуртай, түүнийг хамгаалагч хэн бүхэнд сонирхолтой байх болно. Хүний үйл ажиллагаанаас болж хэцүү байдалд ороод буй хээр талд хүний халамж анхаарал хэрэгтэй болоод байна. Үүнд экологийн боловсрол болон ухуулга гэгээрлийн хоёр хандлагыг хослуулсан энэ ном туслах болно. цомгийн зураг, гар зургууд, В.М. Смириний ажиглалтын

хэсгүүд (1931–1989) уншигчдад амьтдын хэлбэр, зан төрхийн тухай илүү сайн мэдэхэд туслана. Амьтдын зургуудад хээрийн эдгээр амьтдын (бөхөн, хярс, өмхий хүрэн, болон бусад амьтад) судалгаанд олон жилээ зориулсан мэргэжлийн амьтан судлаачдын бичсэн зүйлүүдийн тойм тайлбаруудыг оруулсан.

номын электрон хувилбарыг (pdf, 7 Мб) доорх хаягаар авч болно :

http://www.biodiversity.ru/publications/books/ecoeducation/Smirin_Steppe_2008_web.pdf

Доорх хаягаар захиалж болно: :

E-mail: biodivers@biodiversity.ru

Тел./факс: (499) 124 71 78, 124 50 22

Объявления Зарлал



Бөхөнгийн харилцан ойлголцлын тунхаглалд нэгдсэн талуудын 2-дахь уулзалт 2010 онд Монголд болно

Монголын байгаль орчин, аялал жуулчлалын яамны талархсан урилгын ачаар 2010 оны 9-р сарын эхэнд Улаанбаатар хотноо бөхөнгийн (*Saiga tatarica tatarica*) хамгаалал, сэргээх, тогтвортой ашиглах харилцан ойлголцлын тухай тунхаглалд нэгдсэн талуудын удаан хүлээгдсэн хоёрдох зөвлөлгөөн болохыг НҮББОХ/НЗХК-ийн нарийн бичгийн газраас баяртай зарлаж байна.

Тунхаглалын зөвлөлгөөнөөс өмнө яамны төлөөлөгчидтэй хоёр өдрийн техникийн

зөвлөлгөөнийг зохион байгуулж бөхөнгийн мэргэжилтнүүд дунд хугацааны олон улсын ажлын хөтөлбөрийн биелэлт болон мониторинг явуулах зэрэг бусад асуудлуудыг хэлэлцэнэ. зөвлөлгөөний тогтсон цаг хугацааг НЗХК-ийн интернет хуудас дээр тавих болно www.cms.int/species/saiga/saiga_meetings.htm. цааш мэдээлэл авахыг хүссэн сонирхогч болон бөхөнгийн мэргэжилтнүүд д-ру Алин Кюль, akuehl@cms.int; secretariat@cms.int хандана уу

Талархал

Бөхөн хамгаалах эвслийн зүгээс сүүлийн 6-н сарын турш бидний үйл ажиллагааг дэмжиж байсан доорх хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлж байна: Мэги Брайнт, Винс Мартин болон Зэрлэг байгалийг хамгаалах сан, Марджори Паркер, Мишель Хакетт, Глория ба Кент Маршаллов, Стивен ба Карин Чейзов, Джой ба Тейлора Конвей, Кеннон ба Боба Хадсонов, Линду Табор-Бек, Джеффла Флокена, Энн Мэри Бургуин ба Бред Робертс, Монфорта Джойса, Ким ба Кевина Никейннов, Мишель Линвилл, East Bay Zoological Society, Марк Герард, Присцилла Петтит, Брентон Хэд, Сюзан Хитинг, Борис Станко, Корину Хертель, Эндрю Холмана, Салли МакМуллен, Даниэл Мулвей, Хеллен Галанд ба Дженни Беттенсет (Spitalfields City Farm), Софи Арлов, Христиана Вензля (www.saiga.de). Бид БХОУС болон FFI-ийн бүх ажилчид, сайн дурынханд, мөн БХОУС жил бүрийн үзэсгэлэнгээс хэдэн жилийн туршид Бхөнгийн мэдээд зориулж зургаа илгээдэг гайхалтай зурагчин Мартин Варонд талархалаа илгээхийг хүссэн юм. Энэ дугаарыг гаргахад дэмжлэг үзүүлсэн байгууллагууд – Rufford Foundation, БХОУС, ЗАХАОУЗ болон ДБХС-Монгол дахь хөтөлбөрийн газарт таларханаа илэрхийлэхийг хүссэн юм.



АГУУЛГА

Үндсэн өгүүлэл

Милнер-Гулланд Э.Дж. Биологич-агнуур зүйчдийн олон улсын холбооны XXIX-р чуулганд хэлэлцээний сэдэв бөхөн байв 1

Мэдээ 2

Эрдэм шинжилгээний өгүүлэлүүд

Цутер Ш. Казахстанд бөхөнгийн шилжилтийн судалгаа..... 9

Ито Т.Й., Шинода М., Есипов А.В., Грачев Ю.А., Милнер-Гулланд Э.Дж. Устюртэд бөхөнгийн шилжилтийг хиймэл дагуул ашиглан судлах төсөл эхэллээ 10

Бүүвэйбаатар Б., Янг Дж.К., Лхагвасүрэн Б., Бергер Дж., Файн А. Монгол бөхөнгийн янзаганы мэнд үлдэлтийн талаар шинэ мэдээнүүд..... 11

Чимэддорж Б. Баруун Монголын Их нууруудын хотгорын бөхөнгийн хамгаалал... 12

Леон Дж., Сингх Н.Дж., Арылов Ю.Н., Обгенова О.Б., Милнер-Гулланд Э.Дж. Бөхөнгийн тархацыг зураглахад нутгийн иргэдийн мэдлэгийг ашиглаж болох уу?.. 13

Миноранский В.А. «Европийн хээрийн ховор амьтдын төвийн » бөхөнгийн эвэртэй шаргачин..... 15

Федосов В.Н. «Яшкульск бөхөн үржүүлгийн төвийн» бэлчээрийн агроболовсруулалт 15

Миноранский В.А. Аскании-Нова шинэ нээлт 16

Төслүүдийн тойм 17

Шинэ бүтээлүүд 19

Зарлал 19

Редакцийн зөвлөл. Их Британи: Э.Дж. Милнер-Гулланд, Лондонгийн эзэн хааны коллеж (e.j.milner-gulland@imperial.ac.uk); Казахстан: А. Бекенов ба Ю. Грачев, Амьтан судлалын хүрээлэн (teriologi@mail.ru); Хятад: А. Кан, WCS- Хятад (akang@wcs.org); Монгол: Б. Лхагвасүрэн ба Б. Чимэддорж, WWF-Монгол (lkhagvasuren@wwf.mn; chimeddorj@wwf.mn); ОХУ: А.Лущекина, Экологи , эволюцийн судалгааны хүрээлэн (rusmabcom@gmail.com) ба Ю. Арылов, Халимагийн бүгд найрамдах улсын зэрлэг амьтны төв (kalmsaiga@mail.ru); Узбекистан: Е. Быкова ба А. Есипов, Амьтан судлалын хүрээлэн (esipov@xnet.uz).

Та бүхнийг 6 хэлний аль дуртайгаар нь материалаа ирүүлэхийг урьж байна. Дараах хаягаар esipov@xnet.uz, saigaconservationalliance@yahoo.co.uk эсвэл редакторуудын аль нэгнийх нь хаягаар илгээнэ үү. сэтгүүлийг жилд хоёр удаа гаргадаг.

энэ сэтгүүл online хэлбэрээр дараах сайтуудад www.saiga-conservation.com, <http://saigak.biodiversity.ru/publications.html> ба <http://www.wildlifewarden.net/wcs/mini/Saiga-Chinese.pdf.mөн> түүнчлэн pdf, эсвэл или по запросу в виде твердой копии на англи, казах, хятад, монгол, орос болон узбек хэл дээр сэтгүүл хувилбараараа байгаа.